# УЛААНБААТАР ХОТЫН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НУТАГ ДАХЬ “АХУЙ МАНДАЛ ДАХИВАР ҮЙЛДВЭР”-ИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

**/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5537266/**

Төсөл хэрэгжүүлэгч: **“АЛТАН ОРШИХУЙ ГРУПП” ХХК**

**УЛААНБААТАР 2025 он**

**ГАРЧИГ**

ОРШИЛ

1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА ..... 1
1.1 Ерөнхий мэдээлэл ..... 1
1.1.1 Төсөл хэрэгжүүлэгч ..... 1
1.1.2 Төслийн зорилго ..... 1
1.1.3 Төслийн эзэмшлийн газар, үйлдвэрийн байршил ..... 1
1.1.4 Газар ашиглалт ..... 2
1.1.5 Үйлдвэрийн хүчин чадал ..... 3
1.2 Төслийн талбай орчмын бүс нутгийн тодорхойлолт ..... 3
1.2.1 Байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт ..... 3
1.2.2 Түүхий эдийн шинж чанар, үйлдвэрийн технологи ..... 5
1.2.3 Нийгэм-эдийн засгийн төлөв байдлын тодорхойлолт ..... 7
1.3 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт ..... 8
1.3.1 Байгаль орчны нөлөөллийн тодорхойлолт ..... 8
1.3.2 Үйлдвэрийн нийгмийн ач холбогдол ..... 9
2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 10
2.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цар хүрээ ..... 10
2.1.1 Менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт ..... 10
2.1.2 БОМТ-ний хамрах хүрээ ..... 10
2.1.3 БОМТ-ний нийт зардал, түүний бүтэц ..... 11
2.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ..... 11
2.3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө ..... 13
2.4 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ ..... 15
2.5 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө ..... 15
2.5.1 Аваар осол гарсан онцгой байдлын үед авах арга хэмжээ ..... 15
2.5.2 Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ ..... 15
2.5.3 Хүний эрүүл мэндийг хамгаалах ..... 16
2.5.4 Хүхрийн хүчил, аюултай хаягдлын мэдээллийн сан, бүртгэл ..... 18
2.5.5 Үйлдвэр танилцуулах аялалын аюулгүй байдал ..... 18
2.6 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө ..... 20
2.7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр ..... 22
2.8 2025 оны БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ..... 24
2.9 2025 оны БОМТ-ний хэрэгжилтийг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө ..... 25
ДҮГНЭЛТ
АШИГЛАСАН МАТЕРИАЛ
ХАВСРАЛТ

# ОРШИЛ

Улаанбаатар хотын Багахангай дүүргийн 1-р хорооны нутаг дэвсгэрт хаягдал шатах тослох материал дахин боловсруулах үйлдвэрлэл эрхэлж байгаа “Алтан оршихуй групп” ХХК нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулах 3.0 га талбайг 15 жилийн хугацаатай эзэмшиж байна. Эзэмшил талбайн 54.0 хувьд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж угсрах ,хатуу хучилттай зам талбай тавих зэргээр идэвхтэй ашиглаж байгаа.

Үйлдвэрийн хувьд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланг байгаль орчны мэргэжлийн байгууллага болох “Төгрөг баян хангай” ХХК-аар хийлгэж байгаль орчны менесентийн 5 жилийн төлөвлөгөөг батлуулж байсан. “Аюултай хог хаягдал дахин боловсруулах” тусгай зөвшөөрлийг гаргуулан авч 2025 оноос үйл ажиллагаа нь урсгал засварын түвшинд байгаа бөгөөд одоо 2025 оны БОМТ боловсруулаад байна.

Үйлдвэрийн 2025 онд хэрэгжүүлэх БОМТ-г боловсруулахад байгаль орчны судалгаа, үнэлгээний мэргэжлийн байгууллага болох “ТӨГРӨГ БАЯН ХАНГАЙ” ХХК-аас мэргэжлийн зөвлөгөө авсан бөгөөд төлөвлөгөөг БОАЖЯ-наас 2019-10-29-ний өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд төлөвлөлтийг тус журмын 3 дугаар хавсралтын “Г”-д заасан агуулгаар боловсруулсан болно.


БОМТ-г нийт 2 бүлэг, 11 дэд бүлэгт багтаан 17 хүснэгт, 9 зураг, схем, график, загварчилал болон тооцооллыг нотлох 12 хавсралтаар баримтжуулсан.

**“АЛТАН ОРШИХУЙ ГРУПП” ХХК**

# 1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

## 1.1 Ерөнхий мэдээлэл

### *1.1.1 Төсөл хэрэгжүүлэгч*

| | | |
|---|---|---|
| Нэг. Ерөнхий мэдээлэл | | |
| 1.1 | Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл | “Алтан Оршихуй Групп” ХХК<br>РД: 5537266, ХХД: 9011321042 |
| 1.2 | Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг | Улаанбаатар хот, Багахангай дүүрэг, 2-р хороо, Хангайн 7-6 тоот, Утас: 70005065, 99110513 |
| 1.3 | Батлагдсан ерөнхий үнэлгээний дүгнэлт | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2024 оны 04 сарын 08-ны өдрийн 12/1558 тоот ерөнхий үнэлгээний батлагдсан дүгнэлт |
| 1.4 | Хог тээвэрлэлийн гэрээ | “Багахангай тохижилт” ОНӨААТҮГ-тэй 2024 оны 01 сарын 10-ны өдөр байгуулсан хог тээврийн гэрээ |
| Хоёр. Төслийн талаарх мэдээлэл | | |
| 2.1 | Төслийн нэр | “Ахуй мандал” дахиварын үйлдвэр |
| 2.2 | Төслийн байршил | Тус үйлдвэр Улаанбаатар хотоос 85 км зайд Улаанбаатар хотын Багахангай дүүргийн 1-р хороо, Үйлдвэрлэлийн хэсэг гудамж, /12340/, 47 тоот хаалганд оршдог бөгөөд талбайн хэмжээ 30000 м2 байна. Улаанбаатар Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай авто зам болон төмөр зам дайран өнгөрөх дэд бүтцийн таатай байршилтай.<br>  <br>Газрын байршил нь орон сууц, олон нийтийн байгууламж бүхий хэсгээс 5 км-ийн зайд байрладаг нь 2017 оны 5 дугаар сарын 12-нд батлагдсан “Хог хаягдлын тухай хууль” –ийн 25.1 дэх шаардлага болон “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105 : 2001 стандартын шаардлагыг хангаж байна. |



| | | |
|---|---|---|
| | |  |
| 2.3 | Төслийн ерөнхий танилцуулга | **Ерөнхий мэдээлэл:**<br><br>Тус компани нь хаягдал тос боловсруулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгыг 2016 оноос эхлэн тавьж ажиллаж байна.<br>- “Алтан Оршихуй Групп” ХХК нь дээр дурдсан хэрэгцээ шаардлага дээр үндэслэн байгаль орчноо хамгаалах, импортыг орлох эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн ажлыг 2012 оноос эхлүүлж одоогийн байдлаар сард тогтмол 70-75 тонн аюултай хог хаягдал болох техникийн хаягдал тосыг дахин боловсруулж 40-45 тонн евро-4 стандартын шаардлага хангасан Дизель түлш үйлдвэрлэж байна.<br>- “Алтан оршихуй групп” ХХК- ийн Ахуй мандал дахиварын үйлдвэр нь 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлж эхэлсэн.<br>- Өөрийн үйлдвэрлэсэн “Монгол Эко” дизель түлшийг Баян суманд байрлах **өөрийн “Баянмандал” ШТС**-ээр дамжуулан борлуулдаг. Мөн гэрээт ШТС-үүдээр дамжуулан борлуулдаг.<br>- *Түүхий эд нийлүүлэгч байгууллагууд:*<br>- Паберлик сервис ХХК, Баян-айраг ХХК, Клейн энержи ази ХХК, СЭБОЦЭ ХХК, ФЛСмидт Монголиа ХХК, Арева майнс ХХК, МАК ХХК, Илт Гоулд ХХК, Олборлолт ХХК, Ханбогд Вейст Менежмент Центр ХХК зэрэг 10 байгууллага байна. /Хавсралтаар хүчинтэй гэрээнүүдийг хавсаргав/<br>**“Монгол эко дизель түлш” худалдан авдаг байгууллага:**<br>- “Наран хүрээтэй уул” ХХК-нд нийлүүлдэг. /Хавсралтаар хүчинтэй гэрээг хавсаргав/<br>- Төслийн талбайд 845 м$^2$ талбайтай 6 метрийн өндөртэй үйлдвэрийн барилга байдаг бөгөөд 62.55м*13.52м хэмжээтэй дулааны цех, боловсруулах цех, оффис, лаборатори, 7 м$^2$ химийн агуулах зэргээс бүрдэнэ. Мөн төслийн талбайд цахилгаан дэд станц, дизель генератор, харуулын байр, 14ш нөөцийн сав зэрэг обьектууд байрлана.<br>**Өнөөдрийг хүртэл:** |


| | | |
|---|---|---|
| | | - *Тус үйлдвэрийн бүтээгдэхүүн “Монгол эко” дизель түлш нь УБД0000302 дугаар бүхий чанарын тохирлын гэрчилгээ авсан буюу евро-4 стандартын шаардлага хангасан* /Агуулагдах хүхрийн хэмжээгээрээ тодорхойлогддог- тус үйлдвэрийн дизель түлш нь стандартаас заасан хэмжээнээс бага хүхрийн агууламжтай тул байгаль орчинд хор багатай/<br>- *Өнөөдрийг хүртэл тус үйлдвэр нийт 5 000 000 литр гаруй тонн хөдөлгүүрийн ашигласан тосыг дахин боловсруулж байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулсан байна.*<br>- *Нийт нөөцийн 50 тн-ийн 14 ширхэг пасспорттай савтай. Үүнээс газар доор байрлалтай 5 сав, ил байрлалтай 9 сав байна.*<br>- *Мөн шинээр үйлдвэрийн өргөтгөл хийж нөөцийн 2ш ёмкоос нэмэх, ногоон байгууламж, үйлдвэрийн байр, технологийн хувьд шинэчлэлт хийж жилд 12500тн хаягдал дахин боловсруулж дизель түлш үйлдвэрлэх, авто машины зогсоол, дотоод автомашины зам тавих, гэрэлтүүлэг хийх, химийн бодисын агуулахаа өргөтгөх зэрэг өргөтгөл хийгдэнэ.*<br>**Тус үйлдвэрийн амжилтаас***:*<br>- *Нийгмийн хариуцлагатай байгууллага өргөмжлөл цом,*<br>- *Улаанбаатар хотын 374 жилийн ойн нэрэмжит “Бүтээн байгуулалтын дээд шагнал”*<br>- *Олон улсын “Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох чадавхийг бэхжүүлэх, олон нийтийн оролцоог дэмжих сургалт-семинар”, 2015 он*<br>- *Тус группын ерөнхийлөгч нь Байгаль орчны тэргүүний ажилтан,*<br>- *Аж үйлдвэрийн тэргүүний ажилтан гэх мэт олон шагнал, өргөмжлөл цом авсан байна* |
| 2.4 | Төслийн зорилго | Байгальд үл шингэх хог хаягдлыг дахин боловсруулж, байгаль орчныг хамгаалах бодлого хөтөлбөрүүдийг дэмжсэн үйл ажиллагаа явуулах, |

<table>
<tr>
<td>2.5</td>
<td>Төслийн ерөнхий төлөвлөгөө</td>
<td>



Тус үйлдвэр нь хаягдал тос болон бүтээгдэхүүн хадгалах, нэрэх цех гэсэн үйлдвэрлэлийн үндсэн хэсэгтэй.<br>Үйлдвэр нь жилд 9000 тонн Дизель түлш болон 2500тн мазут бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал бүхий тос хадгалах болон нэрэх хэсэг гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.
</td>
</tr>
<tr>
<td>2.5</td>
<td>Төслийн хүчин чадал</td>
<td>
<ul>
<li>Одоогийн байдлаар тус үйлдвэр нь хоногт 26тн дизель түлш, 8 тонн мазут үйлдвэрлэх хүчин чадалтай байна.</li>
<li>Ахуй мандал шинэ төсөл хэрэгжсэнээр өдөрт 40тн, Жилд 12500 тонн хаягдал тосыг боловсруулна.</li>
<li>Төсөлд одоогоор нийт 10 хүн ажиллаж байна. Цаашид 66 хүн ажиллана.</li>
<li>Жилд 312 хоног 4 ээлжээр ажиллана.</li>
</ul>
<table>
<tr><th>№</th><th>Бүтээгдэхүүн</th><th>Төрөл стандарт</th><th>Хэмжих нэгж</th><th>Үйлдвэрлэл, жилд</th></tr>
<tr><td>1</td><td>Хаягдал тос</td><td>Байгууллагын стандарт</td><td>тн</td><td>12500</td></tr>
<tr><td>2</td><td>Дизель түлш</td><td>MNS 6861:2020</td><td>тн</td><td>8125</td></tr>
<tr><td>3</td><td>Мазут</td><td>MNS 3828 : 2008</td><td>тн</td><td>2500</td></tr>
</table>
</td>
</tr>
</table>

| | | |
|---|---|---|
| 2.6 | Төслийн ерөнхий технологи | Хаягдал тос боловсруулах технологийн ерөнхий бүдүүвч<br>  <br><br>Технологийн тоноглолын ерөнхий байдал<br>  <br><br>Хаягдал тос боловсруулах үйлдвэрийн технологийн бүдүүвч |

| | | |
|---|---|---|
| | |  |
| 2.7 | Төслийн хог хаягдал | **Хатуу хог хаягдал:**<br>Ахуйн хатуу хог хаягдлын тооцоогоор хоногт 56.76 кг, жилд 17.7 тн орчим хаягдал гарах бөгөөд харъяа дүүргийнхээ холбогдох /ТҮК/-тэй байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэх, ачуулах асуудлыг цаг тухайд нь тогтмол шийдвэрлэдэг байна. Үйлдвэрлэлийн технологийн хувьд эцсийн шатанд хаягдал мазут шаар үлддэг ба түүнийг дахин шатаана. Бусад хог хаягдлыг “Цэцүүх” ХХК, “Элемент” ХХК зэрэг компаниудад нийлүүлнэ. Шаталтаас үүссэн үнсэн хаягдал болон үнс баригчаас гарсан 2 төрлийн үнсэн хаягдлыг тус тусад төмөр таглаатай саванд хадгалах шаардлагатай. Шаталтаас үүссэн үнсэн хаягдлыг дүүргийн хот тохижуулах газартай хийсэн гэрээний дагуу нийлүүлж зайлуулна.<br>Хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгана.<br>- Дахин ашиглах боломжтой хог хаягдал: Төрөл бүрийн цаас, картон, цаас, хуванцар сав, сав баглаа боодол, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут гэх мэт<br>- Бусад хог хаягдал: Үнс, түргэн муудах хоол хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдлууд<br>- Ахуйн аюултай хог хаягдал: Өөрөө явагч тээврийн хэрэгслээс үүсэх хаягдал /ашигласан тос, масло, үл хөлдөх шингэн, дугуй/ унтраалга-залгуурын төхөөрөмж, өдрийн гэрэл, электрон барааны хаягдал /компьютер, телевизор% гар утас/ цэвэрлэгээний бодис, зарим тусгай батерей зэргүүд хамаарна.<br>*Доорхи зургийн дагуу хог хаяглдыг ялгаж хаях шаардлагатай* |

| | | |
|---|---|---|
| | |  <br>**Шингэн хог хаягдал:**<br>Ахуйн шингэн хог хаягдлын тооцоогоор хоногт үйлдвэрийн нэг ажилтны усны нормын дагуу өдөрт 80 литр бөгөөд нийт 66 ажилтантай гэж үзвэл хоногт 5.28 м$^3$, жилд 312 хоног ажиллах хугацаанд нийт хэрэглэх усны хэмжээ 1647.36 м$^3$/жил, үүнээс 70%-ийг хаягдал ус гэж үзвэл 1153.152 м$^3$/жил болно. Төслөөс гарсан ахуйн бохир усыг зөөврийн аргаар 5 тонны багтаамж даац бүхий зориулалтын машинаар соруулна. “МҮТТ” ХХК-ийн дотоодод үйлдвэрлэж байгаа бохир ус агуулах 30м3 ын бохирын танк (бохироо соруулах худагт таг, агааржуулалтын хоолойтой сэт) –ыг суурилалтын ажлыг мэргэжлийн компаниар хийлгүүлж, газрын хэвлийд хөлдөлтийн түвшингээс доор 4-5 метрт байгуулж ашигладаг. Бохир соруулах гэрээтэй.<br>   <br>**Хийн хаягдал:**<br>Үйлдвэр нь бүрэн хүчин чадлаараа ажиллах үед хоногт 3 кг мод, 3 тн мазут, 10 м$^3$ хий шатаах тооцоо гарч байна. Эдгээрээс жилдээ ялгарах хүлэмжийн хийн тооцоогоор хаягдал хийн агууламж 450.1 м3/цаг, нэг жилд 9948.5кг/жил хий ялгаруулах ба үүнээс мод 2118.5кг/жил, мазут 4620 кг/жил, хий 7222 кг/жил болно.[1] Жилд ялгаруулах хүлэмжийн хийг багасгах зорилгоор үйлдвэрийн орчинд 628 мод тарихаар төлөвлөж өгсөн байна. Нэг модны хүлэмжийн хийг шингээх чадвар (21 кг/жил) байна. |
| 2.7 | Ариун цэврийн байгууламж | Үйлдвэрийн байран дотор төвлөрсөн ариун цэврийн байгууламжтай бөгөөд байгаль орчин, ариун цэврийн цаасыг зөв зохистой ашиглах, хувийн ариун цэвэр сахих соёлын тухай санамжуудыг байрлуулж ба экологийн боловсролын булан бий болгосон. |

[1] ТЭЗҮ, 118-р хуу

| | | |
|---|---|---|
| | |  |
| 2.8 | Усан хангамж | ✓ Үйлдвэрийн газрын цэвэр усны хангамжийг нийтийн гүний худгаас хангана. Үйлдвэрийн байрнаас 1.5 км зайтай байрладаг бөгөөд эрүүл ахуйн бүсийн шаардлага хангаж байна.<br>✓ Төслийн үйл ажиллагааны эхэнд дулаан, унд ахуйн болон ахуйн хаягдал бохир усыг доор тусгасанаар шийдэх<br>✓ Төсөл хэрэгжүүлэх компани нь Усны тухай хуулийн 28.6 , 28.11 дэх заалт, 29 дүгээр зүйлд заасны дагуу ус ашиглах зөвшөөрөл, эрхийн бичиг авч, ус ашиглах гэрээ байгуулан ажилладаг. |
| 2.9 | Цахилгаан хангамж |   <br>✓ Цахилгаан хэрэглээгээ нэгдсэн сүлжээ буюу “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ний хүчдэлийн шугамаас трансформатор байгуулсны үндсэн дээр эрчим хүчний асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. Зориулалт бүхий шонгуудыг газарт суулган бэхлэж, цахилгааны утас татах, дэд станц байрлуулах, цахилгааны шугамны гадна ба дотор талын холболтын ажлыг тусгайлсан зураг гаргаж, мэргэжлийн хүмүүсээр өндөр түвшинд гүйцэтгүүлсэн. |
| 2.1 | Дулаан хангамж | ✓ Тус байгууламж нь халаалтанд эрчим хүчний хэмнэлттэй халаалтын систем буюу усан бойлер хэрэглэдэг.<br>✓ Мөн үйлдвэрийн процесс нь нүүрсний галлагаа шаарддаг тул дулаан хангамжийн хувьд хангалттай дулаахан байдаг. |

### *1.1.2 Нийгэм-эдийн засгийн төлөв байдлын тодорхойлолт*

“Алтан оршихуй групп” ХХК-ийн төсөл нь Улаанбаатар хотын Багахангай дүүргийн 1-р хорооны Үйлдвэрлэлийн хэсэг гудамж /12340/-ны 47 тоотод байрладаг.

**Багахангай дүүргийн түүх, уламжлал**

**Дүүргийн үүсэл, хөгжлийн түүх.** Багахангай дүүрэг нь анх 1989 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн БНМАУ, Эдийн засгийн гадаад харилцаа, хангамжийн яамны сайдын 149 дүгээр тушаалаар, Зөвлөлтийн цэргийн ангийн Мааньт хотхоны барилга байгууламжийг хүлээн авч, бараа материал нүүлгэх, хадгалах, хэрэглэгчдэд нийлүүлэх ажлыг зохион байгуулах ашиглалтын захиргааг байгуулж, үүнээс 5 хоногийн дараа, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1989 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 98дугаар тогтоолоор, БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газрын хооронд тохиролцсоны дагуу эх орондоо буцаж байгаа зөвлөлтийн цэргийн анги, нэгтгэлийн хотхонуудыг хүлээн авч ашиглахтай холбогдуулан, Төв аймгийн Мааньт дахь хотхонд тухайн үеийн Эдийн засгийн гадаад харилцаа, хангамжийн яамны харьяа Улаанбаатар хот дахь материал-техникийн хангамжийн зарим баазууд болох Шатахуун, ачаа тээвэр, материал-техник хангамжийн авто баазыг шилжүүлэн байршуулснаар дүүрэг үүсэх эхлэл тавигдсан байна. Үүний дараа БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1989 оны 08 сарын 08-ний өдрийн 126 дугаар тогтоолоор Төв аймгийн Өндөртолгойд шинээр байгуулагдсан үйлдвэрлэлийн газар, соёл боловсрол, үйлчилгээний байгууллагуудыг харьяалсан Төв аймгийн Багахангай хороо байгуулсан байна. АИХ-ын Тэргүүлэгчдийн 1990 оны 170 дугаар зарлигаар Төв аймгийн Багахангай хороог буцаж, нийслэлийн харьяанд оруулсан бөгөөд 1992 оны шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалтын хүрээнд УИХ-ын 18 дугаар тогтоолоор хотын раойн, хороодыг татан буулгаж шинээр Багахангай дүүрэг байгуулснаар өнөөгийн хотын нэг дүүрэг болж өргөжсөн.

Тус дүүрэг Улаанбаатар хоттой 107 км төмөр замаар, 90 км хатуу хучилттай хар замаар холбогдсон бөгөөд Улаанбаатар-Замын-Үүд, Улаанбаатар-Багануур чиглэлийн төмөр замын зангилаа дээр болон Улаанбаатар-Замын-Үүдийн босоо тэнхлэгийн хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг хэсэг дээр оршдог.

Монгол Улсын Их Хурлын 2003 оны 54-р тогтоолоор нийслэлийн Багахангай дүүрэгт “Үйлдвэрлэл технилогийн парк” байгуулах зориулалт, хэлбэр чиглэлийг тодорхойлж өгсөн нь тус дүүргийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон томоохон арга хэмжээ боллоо.

**АЛСЫН ХАРАА:** Дүүргийн хэмжээнд хууль, тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулах, иргэдэд соёлч боловсон үйлчлэх, төрийн байгууллагын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг боловсролыг дээшлүүлж, мэргэшсэн тогтвортой боловсон хүчнээр хангах, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх замаар нийслэлийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллагуудын манлайлагч байх.

**ЭРХЭМ ЗОРИЛГО:** “Төрийн захиргаа, иргэн, хувийн хэвшлийн түншлэлд түшиглэн, үнэн зөв, ил тод мэдээллийн эх сурвалж ашиглан, дүүргийн нийгэм эдийн засгийн хөгжлийн бодит нөхцөлд шинжилгээ хийж, иргэддээ үйлчилдэг, өндөр мэдлэг, ур чадвартай зарчимч мэргэшсэн, төрийн албан хаагчдыг үр дүнтэй, тогтвортой ажиллах орчин нөхцлийг бүрдүүлж, дүүргийн удирдлагад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд оршино”.

\Дүүргийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн бодлогын зорилтууд 2030 он хүртэл




Багахангай дүүргийн газар нутаг, ашиглалт

**Дүүргийн газар нутгийн хэмжээ.** Багахангай дүүрэг нь 140.0 км² нутаг дэвсгэртэй далайн түвшнээс дээш 1614 метр өргөгдсөн. Нийслэлээс өмнө зүгт 90км зайд, баруун хойд талаараа Төв аймгийн Сэргэлэн сум, зүүн болон урд талаараа Баян сумтай хил залган оршдог.

Нийслэлийн алслагдсан дүүргүүдийн нэг юм.




*Зураг 1. Багахангай дүүргийн газарзүйн байрлал*

Багахангай дүүрэг нь 140.0 км² нутаг дэвсгэртэй. 2022 оны байдлаар 1 м2 нутагт 0.03 хүн ноогдож байна. Засаг захиргааны хувьд нийт 2 хороотой байна. Хороо нь засаг захиргааны хувьд Засаг дарга, зохион байгуулагч, нийгмийн ажилтан, олон нийтийн байцаагч, хэсгийн ахлагч, үйлчлэгч гэсэн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

**1-р хороо** нь Нийслэлийн Багахангай дүүргийн 1 дүгээр хороо нь Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу 1992 онд анх байгуулагдсан. Тус хороо нь 8.0 мянган га газар нутагтай зүүн хойд болон хойд талаараа Төв аймгийн Сэргэлэн сум, зүүн талаараа Багахангай дүүргийн 2 дугаар хороо, зүүн урд талаараа Төв аймгийн Баян сумтай хиллэн тал хээрийн бүсэд оршдог.

Тус хороонд 719 өрхийн 2503 хүн амтай. 2022 оны эцэст 16731 толгой мал тоологдсон.

Нутаг дэвсгэрийн 515.5 га буюу 4.3%-д хүн ам суурьшсанаас 2022 оны эцсээр хөдөлмөрийн насны хүн 1345 буюу 53.7%-ийг эзэлж байна. Хорооны хүн амын 168 иргэн хөдөлмөр эрхэлдэггүй, 49 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, оюутан 87, ахмад настан 310 байна.

**2-р хороо** нь Тус хороо нь 6000 га газар нутагтай бөгөөд Багахангай, Багануур, Замын-Үүд чиглэлийн төмөр замын дагуу баруун хойноос урагш 86 км сунаж тогтсон байрлалтай , дүүргийн төвтэй 7км хатуу хучилттай замаар холбогддог. Төвийн эричм хүчний системд бүрэн холбогдсон .

Баруун талаараа тус дүүргийн 1-р хороотой зүүн талаар төв аймгийн баян сумтай хойд талаараа Төв аймгийн Сэргэлэн сумтай хиллэдэг Шугам замын Агуйт Хоолт Цагаанхяр 473-р км Чулуут 480 -р Хангайн Алсын худаг Мааньт Агуйт Булагтай зэрэг зөрлөгүүд Бор үзүүр Нуур Цайдам Замчин орон сууцны 11 Байрны иргэдийг хариуцан төрийн 6 төрийн бус 3 төмөр замын 10 хувийн хэвшлийн 10 Аж ахуй нэгж байгуулагатай хамтран 7 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаага явуулж байна

Тус хороо нь 538 өрхийн 1924 иргэнтэй байна.

**Хүн ам, хөдөлмөр эрхлэлт**

**Дүүргийн нийт хүн ам, өрхийн тоо.** Засаг захиргааны анхан шатны нэгж 2 хороотой. 2022 онд нийт хүн ам 4416 үүнээс 1-р хороо 2503, 2-р хороо 1913 хүн амтай бөгөөд 1230 өрхтэй юм.





*График 1.Багахангай дүүргийн хүн ам зүйн бүтэц*





*График 2. Багахангай дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбарууд /эзлэх хувиар/*

**Хүн амын хөдөлмөр эрхлэлт.** Багахангай дүүргийн хөдөлмөрийн насны хүн ам нийт хүн амын 48%-ийг эзэлж байсан бөгөөд хөдөлмөр эрхлэлт 4 салбарт голчлон зонхилж байна. Үүнд 2 хэсэг буюу 33 хувьд зонхилж буй мал аж ахуйн салбар, тус бүр 17 хувьд зонхилж буй нийгмийн ажил, төрийн захиргаа, батлан хамгаалах болон боловсролын салбарууд бүртгэгджээ.

*Хүснэгт 1. Багахангай, Багануур дүүргийн хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин*

| **Статистик үзүүлэлт** | **Аймаг** | **Хүйс** | **Насны бүлэг** | **2022** |
|---|---|---|---|---|
| Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, % | Багануур, Багахангай | Бүгд | Бүгд | 14.4 |
| Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, % | Багануур, Багахангай | Эрэгтэй | Бүгд | 17.3 |
| Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, % | Багануур, Багахангай | Эмэгтэй | Бүгд | 11 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Ажилгүйдлийн түвшин, % | Багануур, Багаханай | Бүгд | Бүгд | 11.2 |
| Ажилгүйдлийн түвшин, % | Багануур, Багаханай | Эрэгтэй | Бүгд | 15.1 |
| Ажилгүйдлийн түвшин, % | Багануур, Багаханай | Эмэгтэй | Бүгд | 6.3 |
| Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, % | Багануур, Багахангай | Бүгд | Бүгд | 11.2 |
| Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, % | Багануур, Багахангай | Эрэгтэй | Бүгд | 15.1 |
| Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, % | Багануур, Багахангай | Эмэгтэй | Бүгд | 6.3 |
| Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, % | Багануур, Багахангай | Бүгд | Бүгд | 14.3 |
| Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, % | Багануур, Багахангай | Эрэгтэй | Бүгд | 17.3 |
| Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн | Багануур, Багахангай | Эмэгтэй | Бүгд | 10.6 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| түвшин, % | | | | |

Дүүргийн эдийн засгийн үзүүлэлт

**Дүүргийн төсөв:**

Дүүргийн төсвийн нийт орлого 2023 онд 6344425.6 мян.төг болж бүрдсэнээс. Төсвийн нийт орлого 952154.0 мян.төгрөгөөр татварын орлого, 210000.0 мян.төгрөгөөр татварын бус орлого, 301010.7 мян.төгрөгөөр ОНХС-ийн шилжүүлэг, 4881260.9 мян.төгрөгөөр нийслэлийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээр бүрджээ. Энэ нь өмнөх оны(2022) нийт орлогоос 12.7% -иар өссөн үзүүлэлт юм.

Аж үйлдвэр

Дүүргийн нутаг дэвсгэрт төмөрлөгийн 3, хөнгөн цагааны 1, керамзитын 1, бусад чиглэлийн 3 үйлдвэр улирлын чанартай үйл ажиллагаа эрхэлж байна. Уг үйлдвэрүүд ажилласнаар жилд 135 хүнийг ажлын байраар хангаж, дүүргийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байна.

**Мах боловсруулах үйлдвэр.** Багахангай дүүргийн Мах боловсруулах үйлдвэр нь Финлянд улсын хөрөнгө оруулалтаар 1994 онд баригдсан.

Жилд 20000 бод, 20000 бог, 6,5 мянган гахай нядлах нядалгааны цех, хоногт 300 тонн чанамал хиам, 600 тн бүтэн утлагатай хиам үйлдвэрлэх хиаман цех, хоногт ээлжиндээ 1,5 тн мах шуллагааны цех, 500 тн-ын хөлдөөх зоорь, өлөн боловсруулах, арьсанд анхан шатны боловсруулалт хийх цехүүдтэй.

Хөдөө аж ахуй.

**Газар тариалан.** Дүүргийн хэмжээгээр нийт 150 га талбайд үр тариа, мөн 2.1 га талбайд төмс, 80 га талбайд тэжээлийн ургамал, 3.3 га талбайд хүнсний ногоо буюу нийтдээ 235.4 га талбайд тариалалт хийж байна. Үүний 231.47 га талбай нь 1-р хорооны нутагт, үлдсэн багахан хувь нь 2-р хорооны нутагт байна.

**Мал аж ахуй.** Дүүргийн хэмжээнд нийт 28.41 мян.толгой мал байна. Үүнээс:





*График 3. Багахангай дүүргийн мал аж ахуй /малын төрөл, эзлэх хувиар/*

Ус суваг ашиглалтын товчоо

Хэрэглэгчдийг унд ахуйн стандартын шаардлагад нийцсэн усаар тасралтгүй хангах экологийн тэнцвэрийг хадгалах шалгуурт тохирсон усыг байгальд нийлүүлэх эрхэм зорилттой Ус суваг ашиглалтын товчоо нь хоногт 2760 м3 ус олзворлох хүчин чадалтай 4 худаг, 3264 м3 бохир ус татан зайлуулах хүчин чадалтай бохирын станц, 2880 м3 ус хэрэглэгчид түгээх хүчин чадалтай 2 станц, 500м3 багтаамж бүхий төмөр бетонон усан сан, 3790 м3 цэвэр усны 1608 м бохир усны шугамыг хариуцан ажилладаг. 404,0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 10,9 сая эргэлтийн хөрөнгөтэй.



*Зураг 2. Багахангай дүүргийн ус суваг ашиглалтын товчоо*

Эрүүл мэндийн үйлчилгээ

Эмнэлгийн ажилтны ёс зүйг эрхэмлэн дээдэлж эмчлэн сэргийлэх тусламж үйлчилгээг боловсон шуурхай соёлтой чанартай хүртээмжтэй хүргэх чиг бүхий 15 ортой Хүн эмнэлэг, Төмөр замын их эмчийн салбар нь эрүүл мэндийн салбарын хөгжлийг хүн амын эрүүл мэндийг дэмжин хамгаалах 2 талт үйл ажиллагаанд чиглүүлэн халдварт ба халдварт бус өвчлөл, эхийн эндэгдэл, шүд амны хөндийн өвчлөлийг бууруулах тэдгээрээс урьдчилан сэргийлэх эмчилгээ, оношлогооны чанарыг сайжруулах, эрүүл хүн амыг дэмжих, иргэдийн оролцоо хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Жилд 11200 үзлэгээс 5787 урьдчилан сэргийлэх үзлэг хийж гэрийн эргэлтээр 1246 хүн хамруулж, 543 хүн хэвтэн эмчлүүлж байна.




*Зураг 3. Багахангай дүүргийн эрүүл мэндийн төв*

Соёлын ордон

Соёлын талаар явуулж буй бодплого шийдвэрийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх иргэдэд соёл урлагаар үйлчлэх соёлын ордон нь иргэдийн эрэлт хэрэгцээ хүсэл сонирхол насны онцлогт тохируулан соёл хүмүүжил олгох, авьяас билэгийг нээн илрүүлэх, хөгжүүлэх зорилго тавин үйл ажиллагаагаа явуулж ирлээ. Соёлын ордоны дэргэд насны ангилалаар дуу, хөгжим, бүжиг, морин хуурын дугуйлан хичээллэж ардын ёс заншлын танхим, бичил номын сантай болж Соёлын цаг нэвтрүүлэг явуулж хэвшүүллээ.



*Зураг 4. Багахангай дүүргийн соёлын ордон*

Илч-Орд НӨҮГазар

Илч-Орд Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар нь 18,0 мян.ам метр албан үйлчилгээний газар 6,0 мян.ам метр 5 давхар 4 орон сууцны талбайг дулаан дамжуулан 0219 м2 600 м урт төв 084 мм-тэй салбар шугамыг ашиглаж, Герман технилогоор үйлдвэрлэгдсэн КВМ-1, 1,86 маркын 2 зуухаар дүүргийн халаалтын системийг найдвартай ажиллуулж хэрэглэгчдийг дулаанаар хангаж 8 тн-ын даацын Донг-феңг ниссан дизель маркийн автомашинуудаар парк шинэчлэл хийгдсэн. Мөн тус газар нь хот тохижилтын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж дүүргийн өнгө үзэмж тохижилтыг сайжруулахад анхааран ажиллаж байна.

Эрчим хүч

Дүүрэг нь улсын төвлөрсөн эрчим хүчний системд холбогдсон 1600 квт хүчин чадал бүхий 1 дэд станц, цахилгаан дамжуулах 35 кв-ын 200 км урт цахилгаан дамжуулах шугамаар 211,3 сая төгрөгний борлуулалтын орлого оруулдаг. Жилд 47 аж ахуйн нэгжид 2,9 сая квт цахилгаан, 400 гаруй айл өрхөд 0,4 сая.квт цаг эрчим хүчийг үйлдвэрлэн түгээлээ. Төв аймгийн Баянцагаан, Баян сумдыг 35 квт-ын цахилгаан дамжуулах шугамаар тэжээн хариуцдаг, Өндөртолгойн эрчим хүчний хэсэг, Төмөр замын Хайрхан-Агуйт, Булагтай, Багануурын өртөө зөрлөг, тэнд оршин суугчид дүүргийн 2-р хорооны иргэдийг цахилгаан эрчим хүч, ундны цэвэр усаар хангадаг 0,4, 6,10,35 квт-ын 350 м-ийн цахилгаан дамжуулах агаарын шугам 0,4 6,10 кв-ын кабель шугам 6,10 квт-ын хаалттай хуваарилах 3 байгууламж 6,10 кв-ын бүрдмэл хуваарилах 37 байгууламж усны 4 насост станц 11 гүний шахуургат худгийг ажиллуулан хэрэгчдийг эрчим хүчээр найдвартай хангаж байна.

Багахангай өртөө

Багахангай өртөө нь Улаанбаатар-Замын үүд-Багануурын чиглэлд хоногт 22-24 галт тэрэг өнгөрч жилд 15-16,4 сая тонн ачааг тээвэрлэж 4,5-5,2 сая тонн транзит ачааг дэмжин өнгөрүүлж дунджаар 2,5 сая зорчигч дайран өнгөрдөг 2-р зэргийн өртөө юм. Замын 17-р хэсэг нь Багахангай-Багануурын болон гол замын 20 гаруй км зам, 10 гаруй замын арчилгаа засварыг хийж техник үзлэгийн газар хоногт 120 вагонд засвар үйлчилгээ хийн галт

тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.




*Зураг 5. Багахангай өртөө*

Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн тасаг

Иргэдийнхээ аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэрэг гаралтыг бууруулах, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх аврах хор уршгийг арилгах төрийн тусгай үүрэг гүйцэтгэдэг чиг үүрэг бүхий онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн тасгийн бие бүрэлдэхүүн төр иргэдийнхээ өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж өгөгдсөн үүрэг тавигдсан зорилтыг цаг тухайд нь шударгаар биелүүлж ирсэн түүхэн уламжлалтай.

Мэдээллийн сүлжээ

Дүүрэгт үүрэн телефоны 4 опеторын сүлжээг ашигладаг бөгөөд 2006 оноос дүүрэгт орчин үеийн мэдээллийн сүлжээ бүтэц бий болсоноор МТЗ-ын холбооны Рейлкомын шилэн кабелиар аж ахуйн нэгж байгууллага, иргэд үйлчилгээ авч ирсэн бөгөөд өнөөгийн байдлаар шилэн кабелаар өндөр хурдны интернет ашиглах техникийн нөхцөл боломж бүрдээд байна.

Дүүргийн 1-р хороонд кабелийн телевизээр үндэсний 10, гадаадын 15, 2-р хорооны оршин суугчид Төмөр замын кабелийн телевизээр үндэсний 15 суваг, гэр хороололын оршин суугчид үндэсний телевизийн 6 сувгийг нэгэн зэрэг хүлээн авч үзэж байна.

Тус дүүрэг нь Улаанбаатар хоттой 107 км төмөр замаар, 90 км хатуу хучилттай хар замаар холбогдсон бөгөөд Улаанбаатар-Замын-Үүд, Улаанбаатар-Багануур чиглэлийн төмөр замын зангилаа дээр болон Улаанбаатар-Замын-Үүдийн босоо тэнхлэгийн хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг хэсэг дээр оршдог. Монгол Улсын Их Хурлын 2003 оны 54-р тогтоолоор нийслэлийн Багахангай дүүрэгт “Үйлдвэрлэл технилогийн парк” байгуулах зориулалт, хэлбэр чиглэлийг тодорхойлж өгсөн нь тус дүүргийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон томоохон арга хэмжээ боллоо.Тус дүүрэг нь 1992 онд байгуулагдсан бөгөөд одоо засаг захиргааны 2 хороотой, 1045 өрхийн 3724 хүн амтай, 12971 толгой малтай.

## 1.2 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

### *1.2.1 Байгаль орчны нөлөөллийн тодорхойлолт*

Хоѐрдогч түүхий эд ашиглаж нэмүү өртөг бий болгох энэхүү төсөл нь уул уурхай, олборлох салбартай харьцуулахад байгаль орчинд нөлөөлөх байдлаараа сөрөг нөлөө дунд, нөлөөллийн эрчим сул гэж тогтоогдсон.

**Хүснэгт 6. Аюултай хог хаягдал боловсруулах үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн тодорхойлолт**

| № | Төслийн хүрээний сөрөг нөлөөллийн асуудал | Сөрөг нөлөөллийн хэмжээст параметрүүд | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Цэвэр усны нөөцийг газрын доорхи гүний уснаас хангана. | • Унд ахуйн хаягдал ус 216.0м$^3$/жил | |
| 2 | Усыг эргэлтээр ашиглахгүй, байгальд бохир ус хаяна. | • Бохирдуулах бодисын хэмжээ 324 кг | |
| 3 | Төслийн талбайн хөрсний бохирдол | Хөрсөнд аюултай химийн бодис нэвчиж болзошгүй бөгөөд нөлөөлөл төслийн талбайгаас гадагшлахгүй. | |
| 4 | Төслийн талбайн ургамлан нөмрөгийн тахлагдал | Барилга байгууламж бүхий орон зайн хэмжээгээр ургамлан нөмрөг устсан. | Сул орон зайд ногоон бүс тохижуулах боломжтой. |

### *1.2.2 Үйлдвэрийн нийгмийн ач холбогдол.*

Тус үйлдвэрийн бүтээгдэхүүн “Монгол эко” дизель түлш нь УБД0000302 дугаар бүхий чанарын тохирлын гэрчилгээ авсан буюу евро-4 стандартын шаардлага хангасан /Агуулагдах хүхрийн хэмжээгээрээ тодорхойлогддог- тус үйлдвэрийн дизель түлш нь стандартаас заасан хэмжээнээс бага хүхрийн агууламжтай тул байгаль орчинд хор багатай/

Өнөөдрийг хүртэл тус үйлдвэр нийт 5 000 000 литр гаруй тонн хөдөлгүүрийн ашигласан тосыг дахин боловсруулж байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулсан байна.

# 2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ТАЙЛАН

## 2.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн цар хүрээ

### *2.1.1 Менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт*

БОМТ-ний гол зорилго нь үйлдвэрийн үйл ажиллагааны хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх байгаль орчны хяналт, хамгааллын ажлыг багцалж эрх бүхий байгууллагаар батлуулах, гүйцэтгэлийг хангуулж хуульд заасан хугацаанд хэрэгжилтийг тайлангахад оршино. БОМТ үндсэн зорилгынхоо хүрээнд 2025 онд дараах үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах
- Үйлдвэрийн орчинд ногоон бүс тохижуулах
- Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж осол эрсдлээс сэргийлэх арга хэмжээ авах
- Хог хаягдлын оновчтой менежмент хэрэгжүүлэх
- Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Байгаль орчны хамгаалахад удирдлагын оновчтой бодлого төлөвлөж хэрэгжүүлэх
- БОМТ-ний биелэлт, дүүргийн захиргаатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг орон нутагт тайлагнах зэрэг ажил болно.

### *2.1.2 БОМТ-ний хамрах хүрээ*

Төслийн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх 2025 оны БОМТ-г боловсруулахад БОАЖСайдын 2019 оны А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, биелэлтийг тайлагнах” журмыг мөрдсөн ба төсөл нь “ХАА, үйлдвэрлэл”-ийн төслийн ангилалд хамаарна.

### *2.1.3 БОМТ-ний нийт зардал, түүний бүтэц*

2025 оны БОМТ-г хэрэгжүүлэхэд нийт 21.8 сая төгрөг төсөвлөгдөж байгаа ба түүний 70.0 хувийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд, 18.0 хувийг хог хаягдлын менежментийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулсан.

**Хүснэгт 7. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх нийт зардал**

| № | БОМТ-гөөр хийх ажил | Тооцсон зардал | |
|---|---|---|---|
| | | төгрөг | хувь |
| 1 | Сөрөг нөлөөг бууруулах | 990,000.00 | 4.5 |
| 2 | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлт | 1,200,000.00 | 5.5 |
| 3 | Түүх, соёлын өвийг хамгаалах | - | - |
| 4 | Осол эрсдэлийн менемнтийг хэрэгжүүлэх | Дотоод төсөв | - |
| 5 | Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх | 3,900,000.00 | 18.0 |
| 6 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 15,184,000.00 | 70.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | Удирдлагын менежмент | Дотоод төсөв | - |
| 8 | БОМТ-г оршин суугчдад тайлагнах | 500,000.00 | 2.0 |
| **Нийт зардлын дүн** | | **21,774,000.0** | **100.0** |

## 2.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүсэх дараах сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээг агаар, орчны бохирдлын сөрөг нөлөөг бууруулах, ургамал, хөрсний бохирдлыг бууруулах, газрын доорхи усны нөөцийг бохирдлоос хамгаалах чиглэлд тус тус хийнэ. Сөрөг нөлөөг бууруулах төлөвлөгөөт арга хэмжээг хэрэгжүүлэхэд 0.9 сая төгрөг зарцуулах бөгөөд энэ нь БОМТ-г хэрэгжүүлэх нийт зардлын 4.5 хувь нь болно.

**Хүснэгт 8. Үйлдвэрлэлээс үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний биелэлт**

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **Орчны бохирдлын сөрөг нөлөөг бууруулахад** | | | | | | | | | |
| 1 | Орчны бохирдлын сөрөг нөлөө | Үйлдвэрийн агааржуулалтын төхөөрөмжүүдийг урсгал засвар хийх | Үйлдвэр, агуулахын байр | удаа | Үйл ажиллагааны зардалд тооцож тусгасан. | | | жилд 2 удаа | |
| **Газар хөрсний бохирдлын болзошгүй сөрөг нөлөөг бууруулахад** | | | | | | | | | |
| 3 | Ургамал, хөрс бохирдож болзошгүй | Ариутгал халдваргүйжүүлэлт хийнэ. | Ажилдчын хэрэгцээний нүхэн жорлонгийн орчин | удаа | Хог хаягдлын менементийн зардалд тооцогдсон | | | жилд 2 удаа | MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| 4 | | Хуримтлагдсан бохир лагийг цэвэрлэх | Бохирын цооног | удаа | Хог хаягдлын менементийн зардалд тооцогдсон | | | жилд 2 удаа | |
| **Гүний усыг бохирдлоос хамгаалах, болзошгүй сөрөг нөлөөг бууруулахад** | | | | | | | | | |
| 5 | Газрын доорхи ус бохирдож болзошгүй | Хамгаалалтын хашаа хийнэ | Гүний худгийн хамгаалалт хийх | м | 16500 | 60 | 990,000.0 | жилд 1удаа | MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл Ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ |
| **Нийт** | | **990,000 төгрөг** | | | | | | | |

**Үйлдвэрлэлээс үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний биелэлтийн хүрээнд**

1. Үйлдвэрийн агааржуулалтын төхөөрөмжүүд болон үйлдвэрийн хадгалах агуулах, үйлдвэрийн тоног төхөөрөмжүүдийг бүрэн шинэчлэх урсгал засвар хийж байна.





## 2. Гэрээт байгууллагаар ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэдэг. Гэрээ, актыг хавсралтаар оруулав.

БАТЛАВ
“АЛТАН ОРШИХУЙ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Б.АДЪЯСҮРЭН

БАТЛАВ
“SNDR” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.ГАНЗОРИГ

ХАЛДВАРГҮЙТГЭЛ ХИЙХ ГЭРЭЭ
№ 05

2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас СХД-ийн “SNDR” ХХК , түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Г.Ганзориг /цаашид “Гүйцэтгэгч” гэх/, нөгөө талаас “Алтан оршихуй” ХХК түүнийг төлөөлж Б.Адъясүрэн /цаашид Захиалагч гэх/ нар Монгол улсын иргэний хууль, Нийслэлийн худалдаа үйлчилгээний нийтлэг журам, Нийслэлийн иргэдийн хурлын тогтоолыг тус тус удирдлага болгон доорх нөхцөлүүдийг харилцан тохиролцож гэрээ байгуулав.

### 1. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО.

1.1. Гэрээний зорилго нь нийслэлийн нутаг дэвсгэрт түүхий эдээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгж байгууллагын эрүүл ахуй, байгаль орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор ариутгал халдваргүйтгэл хийх, төлбөр төлөх болон талуудын эрх, үүрэг хариуцлагыг зохицуулахад оршино.

### 2. ХАЛДВАРГҮЙТГЭЛ ХИЙХ ХУГАЦАА, ТӨЛБӨР ТООЦОО.

2.1. Урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийн давтамжийн хугацааг тухайн объектын онцлогийг харгалзан 2 тал харилцан тохиролцож сонгон хийнэ.

| № | Халдваргүйтгэл хийх объектын нэр | Талбайн хэмжээ | Хэдэн удаа | М/кв үнэ /төг/ | Үнэ /төг/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дахин боловсруулах үйлдвэр | 1000 м2 | Жилд 2 удаа | 600 | 1 200 000 |
| Нийт | | | | | 1 200 000 |

2.2. Гүйцэтгэгч нь захиалагчид халдваргүйтгэл хийсэн акт болон төлбөрийн нэхэмжлэлийг саадгүй өгөх.
2.3. Захиалагч үйлчилгээ хийсний төлөө гүйцэтгэгчид өгөх төлбөрийг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 14/05 дугаар тогтоолд заасан тарифийн дагуу SNDR ХХК-ийн ХААН банкны 5022067340 тоот дансанд доорх хуваарийн дагуу тушаана.

### 3. NDR ХХК-НИЙ ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

2.4. Дахин боловсруулах үйлдвэрийн орчны талбай зэрэг бүх объектуудыг халдваргүйжүүлэх ажил гүйцэтгэх
2.5. Халдваргүйтгэл хийсэн тухай бүр акт, үйлчилгээний төлбөрийн хуудас бичиж төлбөрийг нэхэмжлэх
2.6. Халдваргүйтгэлийг автомакс, мананцаржуулагч төхөөрөмж, тусгай тоноглогдсон автомашинаар монгол улсын эмийн бүртгэлийн шаардлага хангасан эмийн бэлдмэл, уусмалаар хийж гүйцэтгэх

### 4.АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ЭРХ

2.7. Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй газрынхаа талбайн хэмжээг үнэн зөв гаргасан байх
2.8. Халдваргүйтгэл хийхээс өмнө тухайн объектод заавал механик цэвэрлэгээ хийсэн байх
2.9. Халдваргүйтгэлийн ажил шаардлага хангаагүй гэж үзвэл гүйцэтгэгч байгууллагын удирдлагад хандаж зөрчил дутагдлыг бүрэн арилгуулах
2.10. Халдваргүйтгэл хийх хугацааг хариуцсан мэргэжилтэнд урьдчилан мэдэгдэх
2.11. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 14/05 дугаар тогтоолд заасан тарифаар тооцож төлбөрийг төлөх

### 5.ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

2.12. Захиалагч, гүйцэтгэгчийн аль нэг нь энэ гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.
2.13. Халдваргүйтгэл хийх ажлыг өөр байгууллага, хувь хүнээр хийлгэснээс гарсан хор хохирол, гэм бурууг “SNDR” ХХК хариуцахгүй.

### 6.БУСАД ЗААЛТ

2.14. Энэхүү гэрээ батлагдсан өдрөөс хойш цуцлагдах хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.
2.15. Гэрээнд хоёр тал харилцан тохиролцож өөрчлөлт оруулж болно.
2.16. Гэрээг аль нэг талын санаачлагаар цуцлах шаардлага гарвал 7-оос доошгүй хоногийн өмнө нөгөө талд албан ёсоор мэдэгдэнэ.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

ЗАХИАЛАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
АЛТАН ОРШИХУЙ ХХК ТҮҮНИЙГ ТӨЛӨӨЛЖ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.АДЪЯСҮРЭН
ХАЯГ: БАГАХАНГАЙ ДҮҮРЭГ, 2-Р ХОРОО 7-8
УТАС: 99110513

ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
“SNDR” ХХК ТҮҮНИЙГ ТӨЛӨӨЛЖ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.ГАНЗОРИГ
ХАЯГ: СҮХБААТАР ДҮҮРЭГ, 2-Р ХОРОО, 15-35
Утас : 99170345

3. Хуримтлагдсан бохир лагийг цэвэрлэх

**ШУГАМАН БӨГЛӨРӨЛ ГАРГАХ БОХИР УС ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ**

202[illegible] он 06 сар 2 өдөр № Улаанбаатар хот

Алтан оршихуй Групп ХХК -ын Бохир ус соруулж үйлчлэх гүйцэтгэгч “Хүрэн Толгой Дархан” ХХК хоёр тал доорхи нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**НЭГ. Нийтлэг заалт**

1.1 11-38 УБӨ Daewoo NOVUS маркын 15тн-ы автомашинуудаар зөөж тээвэрлэнэ.

1.2 Цаашид бохир ус тээвэрлэх дуудлага өгөх талыг захиалагч, үйлчилгээг гүйцэтгэх талыг гүйцэтгэгч гэнэ.

1.2 Захиалагчийн хүсэлтээр бохир ус тээвэрлэх үйлчилгээг харилцан тохиролцсоны үндсэн дээр чанартай шуурхай хийж гүйцэтгэнэ.

1.3 Хоёр тал харилцан тохиролцсоноор үйлчилгээний ажлын нэг удаагийн тээвэрлэлт.

800,000 / Гурван зуун мянган /төгрөг байна.

/төгрөг байна.

1.4 Үйлчилгээний ажлыг 202[illegible] оны 06 дугаар 2-ны өдрөөс эхэлж 2026 оны 12 сарын 31 өдөр дуусгана.

**ХОЁР. Захиалагчийн эрх үүрэг**

2.1 Захиалагч тал нь бохир усыг татуулахдаа гүйцэтгэгч талд 80013303 88013303 утсаар нэг өдрийн өмнө дуудлага өгнө үү.

2.2 Бохир ус сорох явцад хяналт тавьж дутуу сорсон тухай бүр үйлчилгээг гүйцэтгэгчид мэдэгдэж шаардлага тавьж доголдлын хугацаог тогтоон өөрийнх нь зардлаар дахин гүйцэтгэнэ.

2.3 Гүйцэтгэгч талтай тохирсоны дагуу аливаа хөнгөлөлтийг нэмэлт нөхцөлд заасны дагуу эдэлнэ.

2.4 Зайлшгүй шаардлагатай нэмэлт ажил /шугам бөглөрөх, лайдах, дулаалах г.м/ гарвал үйлчилгээг гүйцэтгэгчтэй харилцан тохиролцсоны дагуу үйлчилгээг хийлгэнэ. Хэрэв шугам хоолой хөлдсөн тохиолдолд гүйцэтгэгч тал хариуцахгүй.

2.5 Төлбөрийг бэлэн ба дансаар тохирсон графикийн дагуу төлнө.

2.6 Ажлын хөлсийг нэхэмжлэхээс хойш 5 /тав/ хоногын дотор багтаан төлөөгүй тохиолдолд үнийн дүнгийн 0.5%-тай тэнцэх хэмжээний алдангийг захиалагч төлнө.

**ГУРАВ. Гүйцэтгэгчийн эрх үүрэг**

3.1 Үйлчилгээний ажлыг дуудлагын тогтоосон хугацаанд дагуу шуурхай хийж гүйцэтгэнэ.

3.2 Захиалагчийн соруулсан бохирын цооногийг судалж үнийн дүнг тогтоох, өөрчлөх талаар санал тавьж тохиролцоно.

3.3 Ажил гүйцэтгэхээр очсон үед дуудлага өгсөн захиалагч бохирын цооног дээрээ гарч ирж хяналт тавиагүй тохиолдолд үйлчилгээ гүйцэтгэгч ажлаа бүрэн хийж гүйцэтгэсэнд тооцно.

3.4 Үйлчилгээ гүйцэтгэх явцад захиалагчийн алдаанаас болж /бохирын хоолойн бүрэн бус байдал, ус алдалт, цооног, хөлдөлт г.м/ гологдол гарвал өөрдийн тохирсон өртгөөр авхад үйлчилгээ хийж тухайн рейсэн дээр нэмэлт хөлсийг авна.

3.5 Гэрээ дуусах хугацаанаас өмнө урьдчилан мэдэгдэлгүй гэрээг цуцалж өөр байгууллага хувь хүмүүсээр үйлчилгээ хийлгэсэн тохиолдолд гэрээ дуусах хугацаа хүртэл гүйцэтгэгч ажил үүргээ гүйцэтгэсэнд тооцон тухайн хугацаанд гүйцэтгэх байсан ажлын өртгийг нөхөн авна.

**ДӨРӨВ. Талуудын хүлээх хариуцлага**

4.1 Захиалагч болон гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй бол гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0.1% торгууль хүлээнэ.

4.2 Захиалагч гэрээнд заасан үүргийг өөрийн буруугаас биелүүлээгүй бол гүйцэтгэгчид учирсан зардал хохирлыг хариуцана.

4.3 Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргааныг шийдвэрлэж чадахгүйд хүрвэл шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлнэ.

**ТАВ. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл**

5.1 Давагдашгүй хүчин зүйл / тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, цаг агаарын саатал, зам боогдох, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, г.м нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

5.2 Гэрээний үүргийг биелүүлхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

**ЗУРГАА. Нэмэлт нөхцөл**

6.1 Бохирын дуудлагыг урд өдөр нь өгнө.

6.2 Бохирын цооногийг хогтүй цэвэр байлгана

6.3 Бохирын цооног хогтой байснаас гүйцэтгэгч талын машин техникт гэмтэл гарвал гүйцэтгэгч талын хохирлыг захиалагч тал бүрэн хариуцаж барагдуулна.

6.4 Бохирын цооногтой холбоотой нэмэлт үйлчилгээ / лайдах, бөглөрөл гаргах, буудлага хийх, шугамын засвар үйлчилгээ, шугам солих г.м / хийх үед үнэ хөлсийг харилцан тохиролцож гүйцэтгэнэ.

6.5 Бензин шатахууны үнэ нэмэгдэхэд тээврийн хөлсийг тодорхой хувиар нэмнэ.

6.6 Гэрээний хүчинтэй хугацааг аль нэг тал нь цуцлаагүй тохиолдолд гэрээг 1 жилээр сунгасанд тооцно

**ДОЛОО. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах журам**

7.1 Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Захиалагч: Гүйцэтгэгч:

Утас: 9149 9885 Захирал /С.Дарханбатбаяр/

Ня-Бо

Утас

Компанийн регистр: 6346529

Захиалга өгөх утас: 80013303 88013303

Харилцах данс: 2055492111 Голомт банк

Хаяг: БЗД, 13-р хороо, 6-252б тоот

4. Гүний худгийн гадна талд хамгаалалт хийсэн.




## 2.3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

### *2.3.1 Ногоон бүс тохижуулах урт хугацааны төлөвлөлт*

Үйлдвэр үйлдвэрийн хашаан дотроо ногоон бүс тохижуулж хүрээлэн буй орчны чанарыг сайжруулахад 2029 оныг дуустал буюу газар ашиглалтын эрхийн хугацааны туршид хэрэгжүүлэх урт хугацааны төлөвлөгөөг боловсруулсан. Ногоон бүс тохижуулах урт хугацааны төлөвлөлтийг цаг хугацааны дараах хувиарлалтанд авч үзсэн болно.

| № | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Арга хэмжээний цар хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж, мян.төг | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 2025 он | 2026 он | 2027 он | 2028 он | 2029 он |
| 1. | | “ТЭРБУМ МОД” Үндэсний хөдөлгөөний хүрээнд Орон нутгаас санал авсны үндсэн дээр мод тарих ажлыг хийх *(Тайлбар: “Улаанбаатар хотын 2014 онд тарилтад тэнцэх мод сөөгийн тарьц, суулгацын ААНБ-ын судалгаа” “Тооног байгаль” ТББ-ын үнийн дүнгээр авав.)* | Төслийн талбай болон орон нутгийн зааж өгсөн газар | ширхэг | 120 | 10000 | 120ш*10000*5жил =6000.0 | 120ш | 120 ш | 120 ш | 120 ш | 120 ш |
| | Нийт | | | | | | **6000.0** | 1200.0 | 1200.0 | 1200.0 | 1200.0 | 1200.0 |

**Тэрбум модны биелэлтийн хувьд** Багахангай дүүргийн зүгээс 2025 онд мод тариалах ажил зохион байгуулаагүй тул 2026 оны хавар 2025 оны модыг нөхөж тарьж өгөх, 2026 оны модыг намар тарьж өгөхөөр дүүргийн заасан байршилд тарих үүрэг өгч, албан бичгээр тодорхойлолт авсан.



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГА

Өндөр толгой, 1 дүгээр хороо,
Багахангай дүүрэг, Улаанбаатар хот, 12330
Утас: (976) 7049 1010
Цахим хуудас: www.bagakhangai.ub.gov.mn

2025.11.13 № 01/772

танай _____-ны № _____-т

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМАНД

Тус дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр үйлдвэрийн бүсэд Алтан Оршихуй ХХК 2022 оноос үйл ажиллагаагаа эхлэн явуулж байна.

Дүүргийн нутаг дэвсгэрт 2025 оны намрын мод тариалах ажил зохион байгуулагдаагүй тул Алтан Оршихуй ХХК -тай 2026 оны хаврын мод тариалалтад нөхөж тариалахаар хамтран ажиллахаар болсон.

Иймд Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайланг хүлээж авна уу.

Хамтын ажиллагаанд талархсан.

А.СҮХБОЛД

1225050168

## 2.4 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Үйлдвэр холбогдох стандартыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

### *2.4.1 Аваар осол гарсан онцгой байдлын үед авах арга хэмжээний биелэлт*

*1. Онцгой байдал, аваар ослын үед хүн гэмтэх, осол хүрээлэн буй орчинд тархах, зэргэлдээх барилга байгууламжид тархахаас сэргийлэхийн тулд:*

- Галын аюулгүй байдлыг хангах үүднээс тамхи татах, оч, гал гаргах зэргийг хориглосон тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан.




- Бэртэж гэмтсэн хүмүүст эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх анхны




- Аваар осол гарснаас хөрс, усан сан зэрэг хүрээлэн буй орчинд бохирдол тархахаас сэргийлж орц, гарцыг хаах, үйлдвэрийн бүсэд хаалттай арга хэмжээ буюу хашаа, үйлдвэрийн хаяг, гарцыг байгуулсан.



*2. Онцгой байдал, аваар ослын үеийн үйл ажиллагааны дараалал:*

- *Хүхрийн хүчил асгарсан, урссан, сав баглаа боодол задарсан тохиолдолд:* Ашиглалтаас гарсан хар тугалгат-хүхрийн хүчлийн батерейг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах ерөнхий шаардлага MNS 6783:2019” стандартад заасан арга хэмжээг авна;
- *Гал түймэр гарсан тохиолдолд:* Гал гарсан тухай зарлан мэдээллийг онцгой байдлын үеийн журмаар зарлаж, галыг унтраахтай холбоотой арга хэмжээг авна. Үүнд: Ажилчдын хүчийг ашиглах, гал унтраах багт дуудлага өгөх, эмнэлгийн яаралтай тусламж дуудах, онцгой байдлын албанд дуудлага өгөх, гал унтраах хэрэгсэл /гал унтраагч, элс г.м/ гал команд иртэл байгаа нөөц бололцоогоо ашиглан /гал унртаагч, элс г.м ашиглан / галыг унтраах, хүмүүсийг галын голомтоос гаргаж аюулгүй бүсэд хүргэх зэрэг ажиллагааг хамруулахаас гадна ажилчдыг байнгын бэлтгэл сургалтаар хангаж байна.




### *2.4.2 Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний биелэлт*

**Тэмдэг, тэмдэглэгээ хийх.** Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад гарч болзошгүй байгалийн гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Ажилчдын байрны орчинд эрүүл ахуй хамгаалалтын бүсийг хаягдал болон бохирдлын цэгээс 20 м-ийн алслалттай тогтоож халдвар хамгааллын дэглэм сахиж байна.
- Түүхий эдийн болон хүхрийн хүчлийн агуулахын нярав болон техникийн ажилтнууд болон ажиллагсдын аваар ослын үеийн ажил үүргийн хувиарлалт гаргах ба аваар ослын талаар заавалд мэдэгдсэн байх шаардлагатай албан тушаалтнуудын нэрс, харилцах утасны дугаар зэргийг тусгасан байна.
- Түүхий эдийг агуулахад хүлээн авсан болон агуулахаас гаргасан, үйлдвэрлэлд ямар хэмжээтэйг хэрэглэсэн зэрэг бүртгэл тэмдэглэлийг хийж бүртгэлжүүлсэн.




**Зураг 7. Үйлдвэрийн орчинд болон агуулахад хэрэглэх анхааруулах тэмдгүүдийг байршуулсан байна.**

### *2.4.3 Хүний эрүүл мэндийг хамгаалах*

Ажилчдад хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн тухай ойлголтыг хөдөлмөр хамгааллын сургалтаар дэлгэрэнгүй өгч ослын үед авах яаралтай тусламж, зохион байгуулалттай арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүн нэг бүрийн үүргийг тодорхой болгож заасан байна. **Энэ тухай шинэчилсэн хөтөлбөрт маш тодорхой оруулсан. Хавсралтаар оруулаа.**

Ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд нэг удаа оруулах үйлчилгээг **Баянхангай дүүргийн эрүүл мэндийн төвөөс эрт илрүүлэгт орж авч үйлчлүүлсэн.**

БАТЛАВ
АЛТАН ОРШИХУЙ ГРУПП ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.АДЪЯАСҮРЭН

# “АЛТАН ОРШИХУЙ ГРУПП” ХХК-ИЙН “АХУЙ МАНДАЛ” ДАХИВАРЫН ҮЙЛДВЭРИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХЯНАСАН:
ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ОРЛОГЧ, ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН АХЛАХ БАЙЦААГЧ, ДЭД ХУРАНДАА Г.ГАНЗОРИГ

БОЛОВСРУУЛСАН:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН Г.ХИШИГБАЯР

Багахангай дүүрэг
2025 он

**Хүснэгт 14. Осол, эрсдлээс сэргийлэх арга хэмжээний зардал**


| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
1. Нэг талаас “**Элемент”** ХХК РД: /2100061/ /цаашид “**Гүйцэтгэгч**” гэх/ түүнийг төлөөлж, Химийн мэргэжилтэн албан тушаалтай Э.Халиун, нөгөө талаас /цаашид “**Захиалагч**” гэх/-ыг “**Алтан оршихуй групп**”ХХК РД:/5537266/ түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал албан тушаалтай Б.Адъяасүрэн нар харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчны тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам болон бусад холбогдох хууль тогтоомжийн үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь гэрээнд заасан хугацаанд химийн аюултай хог хаягдлыг өөрийн хими технологийн үйлдвэрлүү ачиж тээвэрлэх, зориулалтын шатаах зууханд химийн бодисын аюултай хог хаягдлыг устгах, захиалагч төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлж, хамтран ажиллахад оршино.

1.2. Дараах баримт бичиг гэрээний хавсралт байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

1.2.1 Устгал хийх хог хаягдлын мэдээлэл, үнэ /Хавсралт №1/

1.2.2 Аюултай хог хаягдлын дагалдах бичиг

1.2.3 Захиалагч байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ

1.2.4 “Элемент” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбар

## ХОЁР. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

2.1. Захиалагч дараах эрхтэй:

2.1.1. Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,

2.1.2. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллах, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг шаардах,

2.1.3. Химийн хорт болон аюултай бодисыг устгахдаа зориулалтын дагуу устгаж, булшилсан актаа гаргаж өгөхийг шаардах зэрэг эрхтэй.

2.2. Захиалагч дараах үүрэгтэй:

2.2.1. Аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтын дагуу аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг заавал тэмдэглэсэн байх,

2.2.2. Үүссэн аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын дагуу тасаг нэгжээс нэг цэгт цуглуулан, зориулалтын түр хадгалах байранд хадгалах,

2.2.3. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг бүрдүүлэх. Мөн химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэл дагалдан өгч явуулах,

2.2.4. Аюултай хог хаягдал ачуулсан тээврийн тооцооны хуудсанд ажилласан цаг, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулах,

2.2.5. Хадгалсан хог хаягдлыг хүлээлгэж өгөхдөө бодит хэмжээг бодитоор зөв хэмжих,

2.2.6. Аюултай хог хаягдал тээвэрлэж, устгасан хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлөх,

2.2.7. Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гүйцэтгэгчийн ажилтан бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохиролыг захиалагч бүрэн хариуцлага хүлээх,

2.2.8. Аюултай хог хаягдлаа ачиж тээвэрлэх, захиалга өгсөн үед тээврийн хэрэгсэл очиход бэлэн байх, хариуцсан ажилтаныг байгууллага дээрээ байлгаж, хог хаягдал ачилт хийж өгөх.

2.2.9. Аюултай хог хаягдлаа гэрээний хүчинтэй хугацаанд багтаан 4.3-т заасны дагуу хүлээлгэн өгч устгуулах.

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Гүйцэтгэгч дараах эрхтэй:

3.1.1. Захиалагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,

3.1.2. Аюултай хог хаягдал тээвэрлэсний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй,

3.1.3. Ачиж тээвэрлүүлэх хаягдлыг зориулалтын сав баглаа боодолтой, хаяг шошготой, "аюултай" гэсэн тэмдэглэгээтэй байхыг шаардах, хаяггүй бол тээвэрлэхгүй байх эрхтэй,

3.1.4. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг шаардах эсвэл дагалдах бичиггүй бол хог хаягдлыг тээвэрлэхгүй байх эрхтэй

3.2. Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:

3.2.1. Хог хаягдлыг захиалагчийн өгсөн захиалга, тоо хэмжээ, байршилд тулгуурлан тээвэрлэх хуваарь гарган захиалагчид мэдээлэл өгч зориулалтын тээврийн хэрэгслээр саадгүй тээвэрлэх,

3.2.2. Аюултай хог хаягдлыг хүлээн авах, тээвэрлэх явцад хууль, журам, стандарт шаардлагад заасны дагуу ажиллах, тээврийн хэрэгсэлийн аюулгүй байдал, ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хөдөлмөр аюулгүй байдлыг хангаж, бүрэн хүлээн авах, түүнээс үүдэх аливаа эрсдэл хариуцлагыг бүрэн хариуцах,

3.2.3. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн захиалагч болон гүйцэтгэгчийн ажилтан, бусад этгээд бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохиролыг гүйцэтгэгч бүрэн хариуцах,

3.2.4. Аюултай хог хаягдалтай холбоотой зөрчил илэрсэн болон засаж сайжруулах шаардлагатай санал байгаа тохиолдолд мэдэгдэх,

3.2.5. Аюултай хог хаягдлыг зориулалтын устгалын төвд аюулгүй болгон устгах

3.2.6. Устгал хийгдсэний дараа устгалын акт гаргах тус тус үүрэгтэй,

3.2.7. Тухайн байгууллага дээр гарсан онцгой нөхцөл байдлын улмаас ажиллах тохиолдолд харилцан тохиролцож, гэрээнд заагдсаны дагуу үүргээ биелүүлэх үүрэгтэй. Шаардлагатай бол гэрээнд нэмэлт тодотгол оруулж болно.

3.2.8. Холбогдох хууль тогтоомжид заасан бусад үүрэг

## ДӨРӨВ. ТЭЭВЭРЛЭХ ХУГАЦАА, ТӨЛБӨР ТООЦОО

4.1. Үйлчилгээний төлбөр нь тухайн устгах аргачлалын дагуу устгалын үед аюултай хог хаягдлын хэмжээнээс хамааран, устгал өгөх бүрт тооцож нэхэмжилнэ. Аюултай хог хаягдлын устгалын төлбөрийг хавсралт №1-т тусгав.

4.2. Энэхүү гэрээ 2025 оны 04-р сарын 29-ны өдрөөс 2026 оны 04-р сарын 29-ны өдөр хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэнэ.

4.3. Захиалагч гэрээний баталгаа болгож урьдчилгаа төлбөр болох **1,000,000.0 /Нэг сая/** төгрөгийг Гэрээний 4.6 дахь хэсэгт заасан дансанд байршуулснаар гэрээ батлагдана. Урьдчилгаа төлбөр нь гэрээний хүчинтэй хугацаанд хийгдсэн тээвэрлэлт, устгалын зардлаас хасагдаж тооцогдоно.

4.4. 4.3-т заасан урьдчилгаа төлбөр нь зөвхөн энэхүү гэрээний хүчинтэй хугацаанд үйлчилгээний төлбөрөөс хасагдаж тооцогдоно.

4.5. Аюултай хог хаягдлыг гүйцэтгэгч ачилт тээвэрлэлт хийх үед болон устгалын төвд хүлээн аван нарийн хэмжилт хийх үед гэрээнд заасан хэмжээнээс илүү гарсан тохиолдолд гүйцэтгэлээр захиалагч талаас нэхэмжилнэ.

4.6. Гэрээний төлбөрийг ажил гүйцэтгэж дууссаны дараа гэрээнд заасан журмаар гэрээ дүгнэсэн акт үйлдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор төлбөрийн нэхэмжлэлийг үндэслэн "Элемент" ХХК-ийн **1715164140 /Голомт банк/** тоот дансанд бэлэн бусаар төлнө.

4.7. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаандаа төлбөр төлөгдөөгүй тохиолдолд боломжит хугацааг мэдэгдэж, онцгой обьектыг харгалзан үзэж, энэхүү хугацаанд төлбөр төлөх хүртэл үйлчилгээг тасалдуулахгүй хүргэнэ,

4.8. Төлбөр тооцоог зөвхөн Гэрээний 4.6 дахь хэсэгт заасан байгууллагын дансанд төлөх бөгөөд тус данснаас бусад хувь хүний дансандшилжүүлсэнээс үүдэх хохиролыг гүйцэтгэгч тал хариуцахгүй болно.

4.9. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

## ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

5.1 Талууд гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэм буруутай тал нөгөө талдаа учирсан хохирлыг төлнө.

5.2 Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагыг Гүйцэтгэгч тал хангаж ажиллах бөгөөд ХАБЭА-н зааварчилгааны дагуу ажиллах үүрэгтэй.

5.3 Захиалагч талын байгууллагын бүсэд нэвтэрсэн тохиолдолд захиалагч талаас тавьсан ХАБЭА-н шаардлагыг гүйцэтгэгч тал хангаж ажиллах бөгөөд Элемент ХХК-ийн тээврийн хэрэгслийг давуу эрхийн дагуу хөдөлгөөнд оролцуулна.

5.4 Захиалагч тал гүйцэтгэгч талын ажлаа явуулах боломжоор байгууллагын хүрээнд хангаж өгөх үүрэг хүлээнэ.

5.5 Талууд Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 12 дугаар болон бусад холбогдох зүйлд заасан шаардлагыг ханган хамтран ажиллах үүрэгтэй.

## ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

6.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн гэнэтийн огцом ачаалал зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах, тэдгээрийн хяналтаас гадуур, урьдчилж тооцох ба даван туулах боломжгүй шалтгаануудыг ойлгоно.

6.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа мэдэгдэнэ. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно.

6.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн тухай тодорхойлолтыг холбогдох эрх бүхий байгууллагаас гаргуулж авна. Энэ тохиолдолд Талууд харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.

6.4. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээний үүргээ биелүүлээгүй,эсвэл зохих ёсоор биелүүлээгүй тал нь энэ тухайгаа нотолсон тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.

## ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

7.1. Талууд энэ гэрээг биелүүлэх явцад иргэний болон эрх зүйн маргаанд хамаарагдах асуудлаар бие биедээ өгсөн зөвлөмжийг анхааралдаа авч ажиллана.

7.2. Энэхүү гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд аль болох хэлэлцээрийн аргаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд эс эвлэрвэл захиалагчийн оршин байгаа газрын харьяаллаар Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## НАЙМ. МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ ХАДГАЛАХ

8.1. Талууд энэхүү гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, ажилтан ажиллагсад, харилцагч, үйлчлүүлэгчийн байгууллагын болон ажилтны хувийн нууцад хамааралтай (техник, санхүү, бизнес, хувь хүний эрүүл мэндийн мэдээллийн нууц гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгэн, аман болон бусад хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хүлээнэ.

8.2. Энэхүү гэрээний 8.1-д заасан нөхцөлийг зөрчсөн тал үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа үр дагавар, хохирлыг хуулийн дагуу арилгах үүрэг хүлээнэ.

## ЕС. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

10.1. Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно. Үүнд:

10.1.1. Гэрээний хугацаа дуусаж, гэрээний биелэлтийг дүгнэснээр,

10.1.2. Талууд харилцан тохиролцсож гэрээг цуцалснаар,

10.2. Талууд харилцан тохиролцсоноор гэрээг цуцалж болно. Гэрээг цуцлах тохиолдолд нөгөө талдаа хуанлийн 15-аас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэлд гэрээг цуцлах үндэслэл, цуцлах огноог тодорхой дурдсан байна. Гэрээ дараах үндэслэлээр хугацаанаас өмнө цуцлагдана.Үүнд:

10.2.1. Аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа (2 ба түүнээс дээш удаа) биелүүлээгүй бөгөөд энэ талаар нөгөө талд бичгээр мэдэгдэл шаардлага хүргүүлсэн боловч биелүүлээгүй,

10.2.2. Талууд оролцогч талын нэр хүндэд ноцтой хохирол учруулсан,

10.2.3. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

## АРАВ. ГЭРЭЭНИЙ БАТАЛГАА, БУСАД

11.1. Энэхүү гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

11.2. Талууд харилцан тохиролцвол гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

11.3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал, хүсэлтийг бичгээр үйлдэж 10-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа гэрээнд заасан хаягаар, баталгаат шуудангаар эсвэл биечлэн хүргүүлнэ.

11.4. Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний хугацаа дуусах хүртэл хүчинтэй үйлчилнэ.

11.5. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

11.6. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэх, мэргэжлийн туршлагатай ажилтан, зориулалтын тээврийн хэрэгсэлтэй, ажил гүйцэтгэх, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн холбогдох хууль журмын дагуу шүдаргаар авсан бөгөөд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаагүй болохыг үүгээр баталж байна.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Химийн мэргэжилтэн албан тушаалтай

Халиун...../Э.Халиун/

Утас: 86093790

Нягтлан бодогч албан

тушаалтай...../Н. Пүрэвсүрэн/

Утас: 86103790

/Тамга, тэмдэг/

Харилцах утас: 8610-3790, 9910-7745

Хаяг: Налайх дүүрэг 3-р хороо, Бүс нуур /12610/

Захиалагчийг төлөөлж:

Гүйцэтгэх захирал ажилтан албан тушаалтай

..... /Б.Адъяасүрэн/

Утас: 9198-9859

Е майл: orshikhuialtan@gmail.com

Хаяг: Багахангай дүүрэг, 1р хороо, химийн гудамж, 47-1 тоот

БАТЛАВ
АЛТАН ОРШИХУЙ ГРУПП ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ ХХК Б.АДЪЯАСҮРЭН

# “АЛТАН ОРШИХУЙ ГРУПП” ХХК-ИЙН “АХУЙ МАНДАЛ” ДАХИВАРЫН ҮЙЛДВЭРИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХЯНАСАН:
ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ОРЛОГЧ, ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН АХЛАХ БАЙЦААГЧ, ДЭД ХУРАНДАА Г.ГАНЗОРИГ

БОЛОВСРУУЛСАН:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХАРИУЦСАН АЖИЛТАН Г.ХИШИГБАЯР

Багахангай дүүрэг
2025 он

# ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ

| Д/д | Бүтэц | Хуудасны дугаар |
|---|---|---|
| **Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний үндсэн хэсэг** | | |
| 1 | Нийтлэг үндэслэл | 1-7 |
| 2 | Танилцуулга | 8-17 |
| 3 | Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө | 18-19 |
| 4 | Аюулт үзэгдэл, гамшиг, ослын үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө | 20-31 |
| 5 | Аюулгүй цэгт цугларах, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө | 32 |
| **6** | **Хавсралт** | |
| 6.1. | Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги байгуулсан тушаал | 33-36 |
| 6.2. | Гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалтын бүдүүвч | 37 |
| 6.3. | Холбоо зарлан мэдээллийн схем | 38 |
| 6.4. | Хүч хэрэгсэл, нөөцийн судалгаа | 39 |
| 6.5. | Ажлын зураг | 40-43 |

## Нэгдүгээр бүлэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1.1. Төлөвлөгөөний зорилго**

Алтан оршихуй групп ХХК-ны “Ахуй мандал” дахиварын үйлдвэр нь хаягдал тосыг дахин боловсруулж дизель түлш, мазут үйлдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зорилго нь болзошгүй гамшиг ослоос байгууллагын ажилтан, албан хаагчдын амь нас, эрүүл мэндийг авран хамгаалах, гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, гамшгийг хохирол багатай даван туулах, сэргээн босгоход оршино.

**1.2. Төлөвлөгөөг боловсруулахад баримталсан зарчим**

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахад дараах зарчмыг баримталсан:

-Байгууллагын эрсдэл, эмзэг байдлын болон чадавхын үнэлгээнд тулгуурласан;

-Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй уялдсан;

-Байгууллагын салбар, нэгжийн ажилтан, албан хаагчдын оролцоог хангасан болно.

**1.3. Төлөвлөгөөний хамрах хүрээ**


Энэхүү төлөвлөгөөг Алтан оршихуй групп ХХК-ны “Ахуй мандал” дахиварын үйлдвэрийн ажлын талбайн ойр орчимд, хүн ам суурьшсан газар гамшгийн улмаас хүний эрүүл мэнд, амь нас хохирох, байгаль орчин болон дэд бүтэц ихээр сүйрэх зэрэг их хэмжээний хохирол үүсч болзошгүй болон үүссэн үед авах арга хэмжээний үед ашиглана.

Гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг гамшгийн эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, төлөвлөх, гамшгаас хамгаалах мэдлэг, чадвар олгох чиглэлээр нийт ажилтнуудыг хамруулан өмчийн төрөл, хэлбэрийг үл харгалзан зохион байгуулна. Гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, Гамшгийн эрсдлийг бууруулах, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон холбогдох хууль тогтоомж, салбар тус бүрийн төрийн бодлого, хөтөлбөрийг үндэслэн Алтан оршихуй групп ХХК-ийн болон гэрээт гүйцэтгэгч байгууллагын бүх ажилчид хамаарна.

**1.4. Удирдлага зохион байгуулалт**

Алтан оршихуй групп ХХК-ийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23.1-д заасны дагуу гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, төлөвлөлт, бэлтгэл бэлэн байдлыг хангах, гамшгийн хор уршгийг арилгах удирдлага зохион байгуулалтыг Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дарга хариуцан гүйцэтгэнэ. Аюулт үзэгдэл, гамшиг, осол тохиолдсон үед гамшгаас хамгаалах мэргэжлийн анги үйл ажиллагаа идэвхжиж үүрэг гүйцэтгэнэ.

## ГАМШГААС ХАМГААЛАХ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



## ГАМШГААС ХАМГААЛАХ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

| № | Албан тушаал | Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангид ажиллах албан тушаал | **Гамшгийн өмнөх үед** | **Гамшгийн үед** | **Гамшгийн дараах үед** |
|---|---|---|---|---|---|
| 1. | Үйлдвэрийн дарга | Мэргэжлийн ангийн дарга бөгөөд гамшгийн үеийн удирдлагын байрны дарга | 1. Гамшгийн голомтод ажиллах мэргэжлийн ангийн тактикийн төлөвлөгөөг боловсруулах, тодотгох, хэрэгжүүлэх;<br>2. Жилд 2 удаа мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн мэдээ, бие бүрэлдэхүүн, автомашин, техник, тоног төхөөрөмжийн тоог 6 ба 12 дугаар сард мэдээний маягтын дагуу гаргаж, харьяалах онцгой байдлын байгууллагад хүргүүлэх;<br>3. Мэргэжлийн ангийн бүтэц, бүрэлдэхүүний талаарх саналыг боловсруулж, байгууллагын удирдлагад танилцуулах, гүйцэтгэх үүргийг тодорхойлох, нөөц бүрдүүлэх, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн судалгаа гаргаж, хангах асуудлыг шийдвэрлүүлэх;<br>4. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу бие бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах, сэтгэл зүйн бэлтгэлийг хангуулах;<br>5. Мэргэжлийн ангийн гамшгийн голомтод ажиллах бэлэн байдлыг хангуулах; | 6. Холбогдох удирдах албан тушаалтны шийдвэр ийг тодотгож бие бүрэлдэхүүнийг "яаралтай цугларах" дохиогоор цуглуулж тогтоосон хугацаанд заасан байршилд үүрэг гүйцэтгүүлэхээр бэлэн болгох;<br>7. Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж буй мэргэжлийн ангийг удирдлагаар хангах, нөхцөл байдлыг үнэлэх, шийдвэр гаргах, шуурхай<br>хариу арга хэмжээг төлөвлөх, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;<br>8. Дайчилгаагаар хүч нэмэгдүүлж ирсэн бүлэг, хэсгийг чиглүүлэх;<br>9. Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд оролцож байгаа бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны<br>зааварчилгаа өгөх;<br>10. Онцгой байдлын байгууллага, шуурхай бүлгийн удирдлага, алба, мэргэжлийн ангиудтай харилцан ажиллагааг зохион байгуулах ,<br>мэдээлэл солилцох; | 14. Сэргээн босгох арга хэмжээнд оролцох;<br>15. Хохирлыг тооцох; |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | 11. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах;<br><br>12. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг хоол, ус, дулаан хувцас байраар хангах;<br><br>13. Үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүнийг сэлгэн ажиллуулах, амраах, хүн хүч хэрэгслийн нөөц бүрдүүлэх; | |
| 2. | Ерөнхий инженер | Орлогч бөгөөд төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ажилтан | 1. Мэргэжлийн ангийн даргын эзгүйд түүний үүргийг орлон гүйцэтгэх;<br><br>2. Мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;<br><br>3. Шаардлагатай хүн, хүч техник хэрэгслийн судалгаа гаргах, нүүлгэн шилжүүлэх ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх;<br><br>4. Гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургууль явуулахад шаардлагатай танхим, дадлагын талбай бэлтгэх, бие бүрэлдэхүүнд гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургууль зохион байгуулах;<br><br>5. Хууль тогтоомж, дээд шатны байгууллагын тушаал шийдвэр, албан даалгавар, сэрэмжлүүлэг, гамшиг, ослын нөхцөл байдал, | 6. Гамшиг, ослын нөхцөл байдлыг үнэлж, шийдвэр гаргахад мэргэжлийн ангийн даргад дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах, байгууллага, мэргэжлийн ангитай харилцан ажиллагааг зохион байгуулах;<br>7. Гамшгийн голомтод мэргэжлийн ангийг удирдлагаар хангах, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;<br><br>8. Эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд оролцож байгаа бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх;<br><br>9. Үүссэн нөхцөл байдалд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар үнэн зөв мэдээллийг хэвлэл, мэдээллийн байгууллагад өгөх; | 10. Мэргэжлийн ангийн үйл ажиллагааг тогтворжуулах<br><br>11.Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд бэлэн байдлын үзлэг явуулах, аврах багаж, тоног төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах; |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хор уршгийг арилгах арга хэмжээний талаар мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, ажилтан, албан хаагчдад таниулах, сурталчлах, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх сурталчилгааны материалаар хангах зэрэг ажлыг зохион байгуулах; | | |
| 3. | Технологийн хэлтсийн дарга | Ажиллагаа хариуцсан ажилтан | 1. Хүн хүч хэрэгслийг тодотгох, судалгаа авч нэгтгэх;<br>2. Хүн хүч, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах;<br><br>3. Бие бүрэлдэхүүнд гамшгийн үед хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар дадлага эзэмшүүлэх | 4. Гамшгийн голомтод хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах;<br>5. Гамшгийн голомтод харилцан ажиллагааг зохион байгуулах<br><br>6. Хүн хүч хэрэгслийг нэмэлтээр дайчлах арга хэмжээг зохион байгуулах; | 7. Хүн хүч хэрэгслийг бүртгэх;<br>8. Хохирлын хэмжээг тогтоох, дээд шатны байгууллагад танилцуулах, тайлагнах |
| 4. | Харилцаа холбооны ажилтан | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан | 1. Холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах;<br>2. Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам, яаралтай цугларах бүдүүвчийг боловсруулж<br><br>батлуулах, тухай бүр тодотгох;<br><br>3. Бие бүрэлдэхүүнд гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага эзэмшүүлэх | 4. Гамшгийн голомтод бүх төрлийн холбоо зохион байгуулах, мэргэжлийн ангийн даргыг холбоо, мэдээллээр хангах;<br>5. Дээд шатны байгууллагад гамшгийн нөхцөл байдлын мэдээг дамжуулах, хүлээн авах, холбооны тасралтгүй ажиллагааг хангах;<br><br>6. Холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгсэлд үзлэг, шалгалт хийх, нөхөн сэлбэх; | |
| 5. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, | Аюулгүй байдал хариуцсан ажилтан | 1. Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд аюулгүй ажиллагааны зааварчилгаа танилцуулж, баталгаажуулах; | 5. Гамшиг, ослын голомтод мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах;<br>6. Аврах ажиллагааг эхлэх, дуусах | 10. Мэргэжлийн ангийн үйл ажиллагаанд дүгнэлт хийж, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | эрүүл ахуйн ажилтан | | 2. Хүн хүч, техник хэрэгслийн бэлэн байдлыг шалгах, хөдөлгөөн үйлдэх чиглэлийн талаар зааварчилгаа өгөх;<br><br>3. Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл түүний ашиглалт, хадгалалтад хяналт тавих, үзлэг шалгалт, засвар үйлчилгээ хийх;<br><br>4. Галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт болон химийн хортой болон аюултай бодисын судалгааг гаргаж, бүртгэл хөтлөх, тэдгээрийн эргэлт, объектын харуул хамгаалалтад хяналт тавих; | хугацааг тогтоож, аюулгүй бүсэд бие бүрэлдэхүүний амрах нөхцөлийг бүрдүүлэх;<br><br>7. Гамшиг, ослын голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүний эрүүл мэндэд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн<br><br>тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах;<br><br>8. Хүч хэрэгслийг гамшиг, ослын голомтод нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;<br><br>9. Гамшгаас хамгаалах дайчилгаа явуулах ажилд дэмжлэг үзүүлэх. | аюулгүй байдлыг сайжруулах; |
| 6. | | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан ажилтан | 1. Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг үзлэг хийх, зааварчилгаа танилцуулах;<br>2. Эрүүл мэндийн талаар заавар зөвлөмж өгөх, эрүүл мэндийг хамгаалах<br><br>3. Хүн, малын гоц халдварт өвчний голомтод ажиллах мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд хамгаалах хувцас хэрэглэл хэрэглэх, ажиллах<br><br>талаар сургах, зааварчилгаа өгөх; | 4. Гамшиг, осол, аюулт үзэгдэлд нэрвэгдсэн хүмүүс эрүүл мэндийн тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулах;<br>5. Гамшиг, ослын голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүний эрүүл мэндэд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн<br><br>тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах;<br><br>6. Эрүүл мэндийн салбарын дайчилгаа явуулах ажлыг зохион байгуулах, төлөвлөх. | |
| 7. | Хангамжийн менежер | Хангалт хариуцсан ажилтан | 1. Мэргэжлийн ангийн үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх, хангалтын төлөвлөгөө боловсруулах<br>2. Гамшгийн хор уршгийг | 4. Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг байр, цэвэр ус, хоол хүнс, эм, ороох боох материалаар хангах<br>5. Голомтод үүрэг гүйцэтгэж байгаа техник, тоног төхөөрөмжийг шатах тослох | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | арилгах ажиллагаанд ашиглагдах техник, багаж хэрэгсэл, шатах тослох материал, цэвэр ус, хоол хүнс, хувцас, бусад бараа материалын нөөцийн судалгаа гаргах, бүрдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, нөхөн сэлбэх<br><br>3. Аврах ажиллагааны багаж хэрэгслийг засварлах, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангуулах, нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах | материалаар хангах<br><br>6. Хохирлын үнэлгээг хийж, мэргэжлийн ангийн даргыг мэдээллээр хангах<br><br>7. Гамшиг, аюул үзэгдэл, ослын хариу арга хэмжээнд зарцуулсан зардал, бараа материалын тайлан гаргаж танилцуулах. | |
| 8. | Нягтлан бодогч | Дэмжлэг үзүүлэх бүлэг хариуцсан ажилтан | 1. Дэмжлэг үзүүлэх бүлгээр ажиллах боломжтой байгууллагуудыг томилгоожуулан, харилцан ажиллагааны төлөвлөгөө боловсруулах<br>2. Бүлгийн хүн, хүч хэрэгслийн судалгааг гарган тодотгох<br><br>3. Бүлгийн гишүүдийг мэргэжлийн байгууллагатай хамтран сургаж дадлагажуулах | 4. Бүлгүүдийг нэгдсэн удирдлагаар хангах;<br>5. Ажлын чиг үүргийг тодорхой болгож, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх боломжоор хангах;<br><br>6. Бүлгийн гишүүдийн эрүүл, аюулгүй ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх. | |

## Хоёрдугаар бүлэг. БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

Алтан оршихуй групп ХХК нь 2012 онд байгуулагдсан бөгөөд үйлдвэрлэл, гадаад болон дотоод худалдаа гэсэн үндсэн чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулж байна. Компани санхүү, аж ахуй, зохион байгуулалтын хувьд дотоод нөөц бололцоогоо бэхжүүлэн инженер, техникийн ажилтан, ажиллагсдаа бүрдүүлж, хөдөлмөрийн гэрээ байгуулан найдвартай ажлын байраар хангана.

Улаанбаатар хотын Багахангай дүүрэгт байрлах “Ахуй Мандал” дахивар боловсруулах үйлдвэрийн 18,000 м2 талбайд тус төслийг хэрэгжүүлнэ. Тус байршил нь УБ хотоос 85 км зайд орших ба УБ-Замын үүд чиглэлийн хатуу хучилттай авто зам болон төмөр зам дайран өнгөрөх дэд бүтцийн таатай байршилтай юм.

“Алтан Оршихуй Групп” ХХК нь дээр дурдсан хэрэгцээ шаардлага дээр үндэслэн байгаль орчноо хамгаалах, импортыг орлох эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн ажлыг 2012 оноос эхлүүлж одоогийн байдлаар сард тогтмол 70-75 тонн аюултай хог хаягдал болох техникийн хаягдал тосыг дахин боловсруулж 40-45 тонн евро-4 стандартын шаардлага хангасан Дизель түлш үйлдвэрлэж байна. /2023 оны байдлаар/

“Ахуй Мандал" үйлдвэрийн нь тус үйл хэргээ улам бүр өргөжүүлж хоногт боловсруулах аюултай хог хаягдлын хэмжээгээ нэмэгдүүлэхээс гадна мөн импортыг орлох эцсийн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлж хоногт 40 тонн хаягдал тосоор 65 хувийн гарцтай 26 тонн Дизель түлш, 8 тн мазут үйлдвэрлэнэ гэсэн зорилт өмнөө тавьсан. Энэхүү төслөөр бид дэлхийн стандартад нийцсэн дэвшилтэт технологийг Монгол нутагт нутагшуулан Монгол улсын хэмжээнд үйлдвэрлэгдэж буй нийт техникийн хаягдал тосыг дахин боловсруулж импортыг орлох эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ингэхдээ олон улсын стандартын дагуу аюул осолгүй, нийгмийн хангамж өндөртэй, амьдарч ажиллахад таатай хөдөлмөр эрхлэлтийг бий болгож Монгол улсын хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах үндсэн зорилгыг өмнөө тавин ажиллаж байна



**Компаний боловсон хүчин:** “Алтан оршихуй групп” ХХК өнөөгийн байдлаар нийт 10 гаран ажилтантай ажиллаж байна. Эхний ээлжинд үйлдвэр ажиллагаанд орсоноор анхан шатанд 66 гаруй ажилтантай байх ба цаашид үйлдвэрийн бүтээн байгуулалт өсөн нэмэгдэхийн хирээр ажилчдыг сурган хөгжүүлж мэргэжлийн боловсон хүчний ажлын байр нэмэгдэх боломжтой юм.

**Барилга байгууламж:** Хөрөнгө оруулагчдын санаачлагаар 2022 онд зураг төслийг боловсруулж, барилга байгууламж барих ажлыг хэрэгжүүлсэн юм. Тус үйлдвэр нь хаягдал тос болон бүтээгдэхүүн хадгалах, нэрэх цех гэсэн үйлдвэрлэлийн үндсэн хэсэгтэй. Үйлдвэр нь жилд 9000 тонн Дизель түлш болон мазут бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал бүхий тос хадгалах болон нэрэх хэсэг гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

“Ахуй мандал” дахиварын үйлдвэр нь үйлдвэрлэлийн талбай, хаягдал тос хадгалах талбай, бүтээгдэхүүн хураах талбай, усан сан, цахилгаан дэд станц, оффисын барилга, ногоон байгууламж зэргээс бүтнэ. Үйлдвэрийн үндсэн түүхий эд болох ажилласан тос, үйлдвэрээс гарах бүтээгдэхүүн Дизель түлш нь тэсрэлтийн болон галын аюултай, хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд хортой химийн нэгдлүүд учраас Газрын тосны бүтээгдэхүүний агуулах. Галын аюулгүйн дүрэм, Барилгын норм ба дүрэм БНбД 21-03-04-ын дагуу зэргэлдээх байгууламжуудаас тодорхой зайтай байрлах ёстой байдаг.

**Эрчим хүч:** Цахилгаан хангамжийн эх үүсвэр Манай компаний эрчим хүчний эх үүсвэр нь Баганхангай дүүргийн 10кВ-ын РП-4 хуваарилах байгууламжаас 35/0,4кВ-ын дэд станц барьж тэжээхээр төлөвлөсөн. Төлөвлөж буй 35/0,4кВ-ын дэд станцын 0,4кВ талаас үйлдвэрийн барилгуудыг 0,4кВ-ын кабель шугам татаж тэжээнэ. Энд үйлдвэрлэлийн бүх цех болон туслах хэсгүүдийн цахилгаан тоног төхөөрөмжүүд орох ба усан сангийн шахуургын цахилгаан хөдөлгүүр нь нэгдүгээр зэрэглэлийн ачаалалд, өөр бусад олонх цахилгаан хэрэглэх төхөөрөмж нь хоёрдугаар зэрэглэлийн ачаалалд хамаарна. Багахангай 110/35/6 кВ-ын дэд станцын тухай Багахангай дүүрэгт одоогоор Монгол улсын төвийн эрчим хүчний системийн УБЦДС ХК-ны 50 мВА чадалтай 110/35/10 кВ-ын 'Багахангай' дэд станц байна. Уг дэд станцаас Багахангай дүүрэг, Төв аймгийн Баян, Баянцагаан, Баянжаргалан сумуудыг 35 кВ-ын 322 км цахилгаан дамжуулах шугамаар эрчим хүчээр хангаж байна.

**Байгаль орчин:** “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн заалтыг мөрдлөг болгон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг сүүлийн үеийн 6 давхар шүүлтүүр бүхий Импульсийн тоос цуглуулагч -120-аар тоноглохоор ТЭЗҮ-г хийж байна.


**Ахуй мандал” үйлдвэрийн технологи, тоног төхөөрөмж:**

“Ахуй мандал” үйлдвэр нь өдөрт 26 тн дизель, 8 тн мазут үйлдвэрлэх хүчин чадал бүхий тоног төхөөрөмжтэйгээр үйл ажиллагаа явуулна. Тус тоног төхөөрөмж нь 4 ш нэрлэгийн тогоо, зуухны хийн галлагааны систем, хөргөх систем, шороон фильтрийн систем гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэж байна.

Дулааны аргаар ашигласан маслыг халааж хэмийн өөрчлөлт болон хувийн жингээр фракц тус бүрийг ялган авна. Үйлдвэрлэлээс гарах бүтээгдэхүүнд хаягдалгүй байдаг давуу талтай. Үйлдвэрлэлээс гарах бүтээгдэхүүн Дизелийн түлш, мазутыг худалдан борлуулна.


Усыг дахин цэвэршүүлж саарал ус хэлбэрээр ашиглана. Газ, хөнгөн фракц, керосин зэргийг галлагаа дэмжих зорилгоор ашиглана. “Ахуй Мандал” дахиварын үйлдвэр нь хаягдал тосыг байгаль орчинд ээлтэй аргаар дахин боловсруулж импортыг орлох Дизель түлш үйлдвэрлэдэг үндэсний үйлдвэрлэгч юм. Үйлдвэрийн тоног төхөөрөмж нь БНХАУлсын Сангчү хотод байрлах “Сангчү жинпөн шиеэ”ХХК-ын /Shangqiu Jinpeng Industrial Co.Ltd./ тосон бүтээгдэхүүн боловсруулах нэрэх тоног төхөөрөмжийг суурилуулсанаар Евро-4 стандартын сайн чанарын түлш болон мазут үйлдвэрлэнэ.

**Үйлдвэрлэлийн технологи:** Нарийн боловсруулах шаардлагатай түүхий тосыг тосон шахуургын тусламжтайгаар нэрэх зууханд хийж, хэвийн даралт эсвэл бага зэрэг сөрөг даралттай нөхцөлд аажмаар халааж, найрлага дахь ус болон хөнгөн фракцын бүрэлдэхүүн хэсгүүд нь 1# -р цамхгаар дамжин конденсацлах системд орж шингэрч тосны танкд орж хуримтлагдана. Шингэрүүлэх боломжгүй хэсэг нь, эргэх холбоогоор шатаах системрүү шилжиж, зуухыг халаах түлш болгон ашиглана. Ус ба хөнгөн фракцын бүрэлдэхүүн хэсгийг ялгаж дууссаны дараа, 1# цамхагийн гаралтын хавхлагыг хааж, 2# дугаар катализаторын цамхагийн хавхлагыг нээнэ. Дизель түлш фракцын бүрэлдэхүүн хий нь катализатор цамхгаар дамжин катализ болсны дараа дээд хоолойгоор дамжин конденсатор руу ордог. Шингэрсэн хэсэг нь тосны саванд цугларч, шингэрэхгүй хэсгийг хий шатаах системийн тусламжтайгаар шатаах хэсэгрүү дамжуулж шатаагдана. Энэ нь түлш эрчим хүчинд хэмнэлттэй бөгөөд байгаль орчноо бохирдуулахгүй давуу талтай. Тодорхой температурт хүрч, Дизель түлшийг гадагшлуулж дууссаны дараа халаалтаа зогсооно. Үлдсэн мазутыг мазутны насосоор шавхаж гарган, тодорхой температурт хөргөөж, мазут хадгалах савруу хийж хадгална. Дараагийн нэрлэгийн ажлыг дээрх горимын дагуу давтан хийнэ.




*Зураг 9. Хаягдал тос боловсруулах технологийн ерөнхий бүдүүвч*

**Технологи ажиллагааны дараалал:** “Ахуй Мандал” үйлдвэрийн ажилласан тос боловсруулах үйлдвэр дээр явагдах технологи үйл ажиллагааны тайлбар:




*Зураг 12.Хаягдал тос боловсруулах үйлдвэрийн технологийн будуувч*

- Уул уурхайн компаниудаас ажилласан тос (ажилласан хөдөлгүүрийн тос)-ыг тусгай зориулалтын автоцистернээр тээвэрлэн авчирч, далд байрлуулсан саванд буулган авна.

- Ажилласан тосыг хүлээн авах далд сав нь хадгалахаас гадна тунгаах үүргийг гүйцэтгэх бөгөөд ажилласан тосон дахь хүнд хэсэг, механик хольцыг тунах боломжийг олгох үүднээс 24 цагаас багагүй хугацаагаар тухайн саванд нь байлгана.

- Тодорхой хугацааны турш тунгаасан тосыг насосоор соруулан нэрлэгийн төхөөрөмжийн цилиндр суурин сав руу оруулна. Энэ үед хэвтээ цилиндр хэлбэрийн суурин “АХУЙ МАНДАЛ” ДАХИВАРЫН ҮЙЛДВЭР, ТЭЗҮ “АЛТАН ОРШИХУЙ ГРУПП” ХХК савны доор байрлах зуухыг мод, хий зэргийг ашиглан галлах ба улмаар зуухан дотор байрлах дулаан солилцогч доторх усны эргэлтийн системээс орж ирсэн ус хална.

- Нэрлэгийн төхөөрөмжид орсон ажилласан тосыг энэхүү халсан усны тусламжтай ойролцоогоор 2600С болтол халаана.
- Цилиндр суурин саван дотор тос халах явцад буцлах хэм багатай нүүрс устөрөгчүүд тасралтгүй ялгаран, цилиндр суурин савны дээр байрлах тавагнууд, тавагнууд дээр байрлуулсан катализатор бүхий босоо багана руу орно. Энд орсон нүүрсустөрөгчид нь

катализаторуудын тусламжтайгаар богино шулуун гинжин эсвэл цагираган бүтэцтэй нүүрсустөрөгчүүдэд хуваагдана. Өөрөөр хэлбэл С1-С16 хүртэл нүүрстөрөгч агуулсан нэгдлүүд үүснэ.

- Үүссэн хий (С1-С4)-н болон шингэн фракциуд цааш конденсацилах төхөөрөмж болон эхний шатлалын сепаратор руу орох ба эндээс хийн ба шингэн фазуудад хуваагдан, хийн фаз нь нэрлэгийн зуух руу холбогдох хоолойгоор орж, зуух руу нийлүүлэгдэнэ.Харин шингэн фазыг 2-3 шаталсан сепаратор дундуур нэвтрүүлэн дизелийн болон мазутын фракци болгон ялгана.

- Ялган авсан дизель түлшний фракцийг гүн цэвэрлэгээнд оруулж, чанарыг стандарт шаардлагад нийцүүлэх зорилгоор дахин 2 шаталсан сепаратор дундуур нэвтрүүлээд, Дизель түлшний фракци хадгалах сав руу орно.

- Дизель түлшний фракци хадгалах савнаас дээж авч, лабораторид шинжлээд дахин сепаратор дундуур нэвтрүүлэх шаардлагатай эсэхийг тодорхойлоод, хэрэв цаашид сепаратор руу оруулах шаардлагагүй гэж үзвэл борлуулах бүтээгдэхүүн хадгалах сав руу оруулна. Үүний дараа дизель түлшний физикийн болон ашиглалтын үзүүлэлтүүдийг Монгол улсад мөрдөгдөж байгаа стандартад нийцүүлэхийн тулд тохирох чанар сайжруулагчийг нэмж өгнө.

- Борлуулалтын саван дахь бүтээгдэхүүнээс дээж авч, үзүүлэлтүүдийг стандарт утгатай нийцэж байгаа эсэхийг шалгасны дараа хэрэв нийцэж байвал хэрэглэгч байгууллагад нийлүүлэхээр автоцистернд насосны тусламжтайгаар шахан оруулна.

- Дизель түлшний гарган авах явцад үүссэн мазутыг мөн шугам хоолойгоор дамжуулан нэрлэгийн төхөөрөмжийн зуух руу нийлүүлж, үйлдвэрийн эрчим хүчний болон худалдаалах зорилгоор ашиглана. Тус төсөлд ашиглагдах тоног төхөөрөмжийг “Ахуй Мандал” үйлдвэрийн үйлдвэрлэлийн онцлогт тохируулан зохион бүтээлгэж байгаа тул угсралт суурилуулалтын нэгдсэн ерөнхий зургийг тоног төхөөрөмжийг үйлдвэрийн газар дээр авчран угсарч суурилуулсны дараа тухайн бодит нөхцөл байдалд үндэслэн зарим холбогдох мэдээллүүдийг нэмж оруулснаар бэлэн болгоно.



## Гуравдугаар бүлэг. БАЙГУУЛЛАГЫН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

БАТЛАВ
АЛТАН ОРШИХУЙ ГРУПП ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.АДЬЯАСҮРЭН

УЛААНБААТАР ХОТ
АЛТАН ОРШИХУЙ ГРУПП ХХК

### “АЛТАН ОРШИХУЙ ГРУПП” ХХК-ИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн | Хугацаа | Хариуцах нэгж/ албан тушаалтан | Хамтран хэрэгжүүлэх | Төсөв/ Санхүүжилт |
|---|---|---|---|---|---|---|
| **Нэг. Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны чиглэлээр** | | | | | | |
| 1.1 | Гамшгаас орон тооны бус мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг гамшиг, аюулт үзэгдэл ослоос урьдчилан сэргийлэх танхимын сургалтад хамруулах | Гамшгаас хамгаалах орон тооны бус мэргэжлийн ангийн гишүүдийн хүлээх үүрэг, чиглэл тодорхой болно | 09 сард | Үйлдвэрийн дарга | Онцгой байдлын хэлтэс | |
| 1.2 | ГТУА ангитай хамтарсан дадлага сургуулийг нийт ажилтанг хамруулан зохион байгуулах | Ажилчдын гал түйрийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг дээшилнэ. | 08 сард | ХАБ-ын ажилтан | Онцгой байдлын хэлтэс ГТУА 80 дугаар анги | 200,000 |
| 1.3 | Засгийн газрын 339 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх | Ажилчдын газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг дээшилнэ. | Жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх долоо хоног Пүрэв гараг | Үйлдвэрийн дарга | ХАБ-ын ажилтан | - |
| 1.4 | Нийт ажилтан албан хаагчдад “Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх” сургалтад хамруулах | Ажилчдын эрүүл мэндийн мэдлэг дээшилнэ. | 09 сард | Үйлдвэрийн дарга | ХАБ-ын ажилтан | 500,000 |
| 1.5 | Компанийн ажилчдад гамшгаас хамгаалах төлөвлөгөөг танилцуулах сургалт зохион байгуулах | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. | 2 дугаар улирал | Үйлдвэрийн дарга | ХАБ-ын ажилтан | |

## Дөрөвдүгээр бүлэг: АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ГАМШИГ, ОСЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 4.1. Газар хөдлөлтийн гамшгийн үед

| д/д | Хэрэгжүүлэх ажил | хугацаа | минут | | | цаг | | | | | | | | | | | | хоног | | | Хариуцах албан тушаалтан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 15 | 30 | 45 | 2 | 4 | 6 | 8 | 10 | 12 | 14 | 16 | 18 | 20 | 22 | 24 | 2 | 3 | 4 | |
| 1 | Дохио хүлээн авмагц тодотгоод албаны даргад яаралтай мэдэгдэх | Ч+15 | ⟺ | | | | | | | | | | | | | | | | | | Анх мэдсэн хүн |
| 2 | Удирдах бүрэлдэхүүний шийдвэрээр ажилчдыг цуглуулах дохиог дамжуулж, цагийн байдлыг Орон тооны бус ангийн дарга болон орон нутгийн ОБГ-т илтгэх, Ажлын цагт /10-15м/ Ажлын бус цагт /30-45м/ | Ч+10-30 | ⟺ | ⟺ | | | | | | | | | | | | | | | | | | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан |
| 3 | Ажилтан албан хаагчдад зарлан мэдээллийг хүргэж ажлын байрнаас гаргах арга хэмжээ авах | Ч+15 | ⟺ | ⟺ | | | | | | | | | | | | | | | | | Үйлдвэрийн дарга |
| 4 | Цугларах цэгт цугларч ажилтан албан хаагчдыг бүртгэх, цагийн байдлыг танилцуулах | Ч+45 | | | ⟺ | ⟺ | ⟺ | | | | | | | | | | | | | | Үйлдвэрийн дарга |
| 5 | Ажилтан алба хаагчдын гамшгийн үед ажиллах хувийн бэлтгэлийг хангуулах /аяны | Ч+45 | | | ⟺ | ⟺ | ⟺ | | | | | | | | | | | | | | Үйлдвэрийн дарга |

| | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үүргэвч, дулаан хувцас, багаж г.м/ | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 6 | Орон нутгийн Онцгой байдлын хэлтэс, мэргэжлийн байгууллагаас өгсөн үүргийн дагуу ажиллах | Ч+45 аас | | | | | | | | | | | | | | | | | | | Удирдах бүрэлдэхүүн |
| 7 | Шаардлагатай хоол хүнс, цэвэр усны нөөцийг татан авах ажлыг зохион байгуулах | Ч+12,45 | | | | | | | | | | | | | | | | | | | Хангалт хариуцсан ажилтан |

| Газар хөдлөлтийн гамшгийн үед авах арга хэмжээ /Дэлгэрэнгүй/ | | | |
|---|---|---|---|
| **Бэлэн байдал** | **Гамшгийн өмнө (мэдэгдэж буй тохиолдолд)** | **Гамшгийн үед** | **Гамшгийн дараа** |
| • Гал унтраах тоног төхөөрөмж, багаж зэвсэг, гамшгийн үед хэрэглэх хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг ямагт хангах<br>• Ажилтан албан хаагчдад сургалт тогтмол явуулах<br>• Гамшгийн үед хэрхэн холбоо барих , мэдээлэх явцыг тодорхой байлгах | • Үйлдвэрийн цахилгааны эх үүсвэрийг салгах<br>• Барилга байгууламжийг тусгаарлах<br>• Ажилчид болон зочдыг нүүлгэн шилжүүлэх<br>• Чухал эд хөрөнгө, бичиг баримтыг аюулгүй газарт байрлуулах<br>• Холбооны хэрэгслүүд хэвийн ажиллагаатай эсэхийг баталгаажуулах. | **Үйлдвэрийн дарга:**<br>• Дуут дохиог ажиллуулна.<br>• Объектийн цахилгааны эх үүсвэрийг салгана<br>• Онцгой байдлын газарт мэдэгдэнэ<br>• Өглөөний ирцийн бүртгэл болон харуул хамгаалалтын ажилтны зочдын бүртгэлийн дагуу бүх хүмүүсийг бүртгэнэ.<br>• Компанийн ерөнхий захиралд цагийн байдлыг мэдээлнэ<br>• Албаны байгууллагуудаас цаг үеийн байдлын мэдээг тогтмол авна.<br>• Орон нутгийн ОБГ-н хэлтэстэй хамтран гамшиг, ослын үед авах арга хэмжээг эхлүүлнэ<br>**Ажилчид**:<br>• Дуут дохио сонсмогц ажлаа зогсоож цуглах цэг дээр очиж бүртгүүлнэ<br>• Дараагийн зааварчилгааг хүлээнэ<br>• Дараагийн зааварчилгаа өгтөл цэгийг орхихгүй байна<br>**Компанийн Удирдах бүрэлдэхүүн:**<br>• Гамшгийн үед гамшгийн бүс дэх ажилтан албан хаагчдыг шаардлагатай мэдээлэл, мэргэжлийн туслалцаагаар дэмжлэгээр хангана | **Компанийн Удирдах бүрэлдэхүүн:**<br>• Ослын газрыг тусгаарлаж, үл нэвтрэх бүс тогтооно.<br>• Орон нутгийн ОБГ-ийн хэлтэстэй хамтран гамшиг, ослыг дараа авах хариу арга хэмжээг эхлүүлнэ<br>• Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар орон нутгийн эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллаж, туслалцаа үзүүлнэ<br>**Ажилтан албан хаагчид:**<br>• Орон нутгийн ОБГ-ийн хэлтэс болон Компанийн Удирдах бүрэлдэхүүний шийдвэр, зааварчилгааны дагуу сэргээн босгох ажиллагаанд оролцно |

## 4.2 Цасан болон шороон шуурганы гамшгийн үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө

| д/д | Хэрэгжүүлэх ажил | хугацаа | минут | | | цаг | | | | | | | | | | | | хоног | | | Хариуцах албан тшаалтан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 15 | 30 | 45 | 2 | 4 | 6 | 8 | 10 | 12 | 14 | 16 | 18 | 20 | 22 | 24 | 2 | 3 | 4 | |
| 1 | Гамшиг, ослын тухай мэдээг хүлээн авч Компанийн удирдлагад мэдээлнэ | Ч+15 | ⟺ | | | | | | | | | | | | | | | | | | Анх мэдсэн хүн |
| 2 | Цугларах дохиог дамжуулж, цагийн байдлыг Компанийн удирдлагад мэдэгдэж, орон нутгийн ОБГ-ийн хэлтэст илтгэх, Ажлын цагт /10-15м/ Ажлын бус цагт /30-45м/ | Ч+10-30 | | ⟺ | | | | | | | | | | | | | | | | | Үйлдвэрийн дарга |
| 3 | Ажилтан албан хаагчдад зарлан мэдээллийг хүргэж ажлын байрнаас гаргах арга хэмжээ авах | Ч+15 | | ⟺ | | | | | | | | | | | | | | | | | Үйлдвэрийн дарга |
| 4 | Цугларах байранд цугларч ажилтан албан хаагчдыг бүртгэх, цагийн байдлыг танилцуулах | Ч+10-15 | ⟺ | | | | | | | | | | | | | | | | | | Үйлдвэрийн дарга |
| 5 | Ажилтан алба хаагчдын гамшгийн үед ажиллах хувийн бэлтгэлийг | Ч+15-30 | | ⟺ | ⟺ | | | | | | | | | | | | | | | | ХАБ-ын ажилтан |

| | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хангуулах /аяны үүргэвч, дулаан хувцас, багаж г.м/ | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 6 | Орон нутгийн ОБГ-ийн хэлтэс, мэргэжлийн байгууллагаас өгсөн үүргийн дагуу ажиллах | Ч+45 аас | | | | | | | | | | | | | | | | | | | Нийт ажиллагсад |
| 7 | Шаардлагатай хоол хүнс, цэвэр усны нөөцийг татан авах ажлыг зохион байгуулах | Ч+12,45 | | | | | | | | | | | | | | | | | | | Ар тал, хангалт, санхүү хариуцсан ажилтан |

"АЛТАН ОРШИХУЙ ГРУПП" ХХК
Улаанбаатар хот Багахангай дүүрэг
1-р хороо, химийн гудамж
Утас: 91989859
E-mail: orshikhualtan@gmail.com
Төв шуудан. ш/х-2018 Улаанбаатар-15160

2024.12.24 №24/05
танай -ны № -т

Гамшгаас хамгаалах орон тооны бус мэргэжлийн анги байгуулах тухай

# “Алтан оршихуй групп” ХХК-ийн гүйцэтгэх захирлын тушаал

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь заалт, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаал, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны А/379 дугаар “Дүрэм батлах тухай” тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.”Алтан оршихуй групп” ХХК-ны “Ахуй мандал” дахиварын үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангах, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий гамшгаас хамгаалах орон тооны бус мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хувцас, багаж хэрэгслийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Орон тооны бус мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, ажилтан алба хаагчдыг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж дадлагажуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах, мэргэжлийн ангид хөтлөгдөх баримт бичгүүдийг тухай бүр шинэчилж байхыг гамшгаас хамгаалах орон тооны бус мэргэжлийн ангийн дарга бөгөөд үйлдвэрийн даргад даалгасугай.

3.Гамшгаас хамгаалах хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалтад заасны дагуу гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлыг төлөвлөх, зориулалтын дагуу зарцуулах, орон тооны бус мэргэжлийн ангид шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэж, ажиллах нөхцөлөөр хангахыг нягтлан бодогч-д үүрэг болгосугай.

**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.АДЪЯАСҮРЭН**

УЛААНБААТАР ХОТ
АЛТАН ОРШИХУЙ ГРУПП ХХК
9024060435
5537266 СБТ25422

Захирлын 2024 оны 12 дугаар сарын 24-ны
өдрийн 24/05тоот тушаалын нэгдүгээр
хавсралт

Гамшгаас хамгаалах орон тооны бус мэргэжлийн ангийн
бүрэлдэхүүн

| д/д | Албан тушаал | | Овог, нэр |
|---|---|---|---|
| | Томилгоожсон | Үндсэн | |
| 1. | Мэргэжлийн ангийн дарга | Үйлдвэрийн дарга | |
| 2. | Орлогч бөгөөд төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ажилтан | Ерөнхий инженер | |
| 3. | Ажиллагаа хариуцсан ажилтан | Технологийн хэлтэс дарга | |
| 4. | Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан | Харилцаа холбооны ажилтан | |
| 5. | Аюулгүй байдал хариуцсан ажилтан | Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан | |
| 6. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан ажилтан | Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан | |
| 7. | Хангалт хариуцсан ажилтан | Хангамжийн менежер | |
| 8. | Дэмжлэг үзүүлэх бүлэг хариуцсан ажилтан | Нягтлан бодогч | |


Захирлын 2024 оны 12 дугаар сарын 24-ны
Өдрийн 24/05 тоот тушаалын хоёрдугаар
хавсралт

Гамшгаас хамгаалах орон тооны бус мэргэжлийн ангийн ажлын хувцас, багаж хэрэгслийн жагсаалт

| д/д | Ажлын хувцас, багаж хэрэгслийн нэр | Хэмжих нэгж | Тоо ширхэг |
|---|---|---|---|
| 1 | Нүдний хамгаалах хэрэгсэл | ширхэг | 20 |
| 2 | Малгай, каск | Ширхэг | 20 |
| 3 | Ажлын хувцас /өвөл, зуны/ | Хос | 30 |
| 4 | Ажлын гутал | хос | 30 |
| 5 | Бээлий | хос | 30 |
| 6 | Цув | ширхэг | 10 |
| 7 | Гар чийдэн | ширхэг | 10 |
| 8 | Олс | метр | 100 |
| 9 | Ган татлага /тросс/ | ширхэг | 8 |
| 10 | Хүрз | ширхэг | 8 |
| 11 | Царил | | 5 |
| 12 | Эмийн сан, анхны тусламжийн иж бүрдэл | хайрцаг | 2 |
| 13 | Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл | 5 кг | 15 |


### 6.2. Гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалт, зарлан мэдээлэл

АЛТАН ОРШИХУЙ ГРУПП ХХК-ийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23.1-д заасны дагуу Компаний гүйцэтгэх захирал хэрэгжүүлж, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, төлөвлөлт, бэлтгэл бэлэн байдлыг хангах, гамшгийн хор уршгийг арилгах удирдлага зохион байгуулалтыг Гамшгаас хамгаалах орон тооны бус мэргэжлийн ангийн дарга хариуцан гүйцэтгэнэ.



## 6.3 Холбоо зарлан мэдээллийн схем

**ЗАРЛАН МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ БҮДҮҮВЧ**




**Тайлбар:** Гамшиг, ослын мэдээллийг орон нутгийн Онцгой комисс, холбогдох байгууллагуудаас авч дээрх маршрутаар зарлан мэдээллийг тараах ба үүрэн телефоны операторууд хэвийн ажиллаж байгаа нөхцөлд утсаар, ажиллаагүй нөхцөлд албаны жижиг унаагаар зарлан мэдээллийг тарааж бүлгийн гишүүд ажлын цагаар 30 минутаас 1 цагийн дотор, ажлын бус цагт 1-ээс 2 цагийн дотор цуглана.

## 6.5 Ажлын болон план зураг


БАТЛАВ: "АЛТАН ОРШИХУЙ ГРУПП" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ..... Б.АДЪЯСҮРЭН

ЗӨВШӨӨРСӨН: ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ:
АХМАД ..... М.МӨНХБОЛД

# ГАЛ ТҮЙМЭР, ГАМШИГ ОСЛЫН ҮЕД ХҮН, ЭД ХӨРӨНГИЙГ АВРАХ ГАРЦЫН СХЕМ

**101** – Гал гарсан үед дуудлага өгөх утас

**105** – Шуурхай бүлэг, аврах анги





**ТАНИХ ТЭМДЭГ**

- Аврах гарцын чиглэл
- Галын хор
- Таны зогсож буй цэг
- Аврах гарц
- Цахилгааны самбар

**ГАЛ ТҮЙМЭР ГАРСАН ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭ:**

1. Харьяа гал унтраах анги болон Онцгой байдлын газар яаралтай мэдэгдэх
2. Гал гарсан тухай хүмүүст мэдэгдэх
3. Цахилгаан хангамжийг салгах
4. Хүмүүс болон эд материал аврах
5. Анхан шатны багаж хэрэгслээр гал унтраах
6. Гал унтраах ангийг тосож авах

# ОБЪЕКТЫН БАЙРШИЛ ХҮРЭЛЦЭН ОЧИХ МАРШРУТ



УСАН ХАНГАМЖ



Байгаль орчны үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

# “АЛТАН ОРШИХУЙ ГРУПП” ХХК-ИЙН УЛААНБААТАР ХОТЫН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БУЙ “АХУЙ МАНДАЛ” ДАХИВАР ҮЙЛДВЭР ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МОНИТОРИНГИЙН ТАЙЛАН

**2025 ОНЫ 05 САР**

Улаанбаатар хот
2025 он

**ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

| | |
|---|---|
| Төслийн нэр: | “Ахуй мандал” дахивар үйлдвэр |
| Байршил: | Улаанбаатар хот, Багахангай дүүрэг, 1-р хороо |
| Гэрээний дугаар: | 25/13 |
| Бичиг баримт: | Байгаль орчны  мониторингийн тайлан |
| Бэлтгэсэн: | “Төгрөг баян хангай” ХХК |
| Бэлтгэсэн огноо: | 2025 оны 05 дугаар сар |
| Судлаачид: | Байгаль орчны мэргэжилтэн Г.Гэрэлмаа |
| | Агаарын шинжээч: Д.Сувд |
| | Хөрсний шинжээч А.Энхтөр |
| | Ургамал судлаач: Н.Мөнгөнчимэг |
| | Усны шинжээч: Р. Нацагдорж |
| | Хээрийн ажиглагч, дээж авагч: Б.Бадрах |

## ГАРЧИГ

1.УДИРТГАЛ ....4
2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ ....5
3. Агаарын чанарын хяналт шинжилгээ ....9
3.1 Судалгааны зорилго ....9
3.2 Судалгааны байршил, хамрагдсан цэгүүд ....9
3.3 Судалгааны арга, дээж авалт ....9
3.4 Хяналт шинжилгээний үр дүн ....10
3.5 Дүгнэлт, зөвлөмж ....11
4. Хөрсний хяналт шинжилгээ ....13
4.1 Судалгааны зорилго ....13
4.2 Судалгааны байршил ....14
4.3 Судалгааны арга, дээж авалт ....15
4.4 Дүгнэлт ....17
4.5 Зөвлөмж: ....17
5. УРГАМЛАН НӨМРӨГИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ....19
5.1 Судалгааны зорилго ....19
5.2. Судалгааны материал аргазүй ....19
5.3 Судалгааны үр дүн ....21
5.4 Зөвлөмж ....22
6. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ....24
3.1 Судалгааны зорилго ....24
3.2 Судалгааны арга зүй ....24
3.3 Судалгаанд ашигласан багаж, тоног төхөөрөмж ....24
3.4 Усны хяналт-шинжилгээний үр дүн ....25
3.5 Дүгнэлт, зөвлөмж ....25
7. ТАЙЛАНГИЙН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ ....27
АШИГЛАСАН НОМ, ХЭВЛЭЛ ....30
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ ....31

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Агаарын чанарын хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил .....9
Хүснэгт 2. Нийт тоос / Нийт жинлэгдэгч бодис / хэмжилтийн үр дүн .....10
Хүснэгт 3. Агаарын бохирдуулагч бодисын хэмжилтийн үр дүн .....11
Хүснэгт 4. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн.....11
Хүснэгт 5. Хөрсний хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил .....14
Хүснэгт 6. Бодис тодорхойлох аргууд.....15
Хүснэгт 7. Хөрсний механик бүрэлдэхүүн .....16
Хүснэгт 8. Хөрсний химийн задлан шинжилгээний дүн.....16
Хүснэгт 9. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж .....17
Хүснэгт 10. Хөрсөн дэх эрүүл ахуйн шинжилгээ.....17
Хүснэгт 11. Ургамлын судалгаа шинжилгээний аргууд.....20
Хүснэгт 12. Худгийн усны ерөнхий химийн шинжилгээ .....25
Хүснэгт 13. Худгийн усны эрүүл ахуйн шинжилгээний дүн, 1 мл усанд.....25
Хүснэгт 14. Худгийн усны хүнд металлын үзүүлэлт.....25

## *ЗУРГИЙН ЖАГСААЛТ*

Зураг 1. Төслийн байршлын зураг .....5
Зураг 2. Төслийн талбайн  агаар сансрын зураг .....5
Зураг 3. Төслийн талбайд хийгдсэн мониторингийн цэгийн байршлын зураг .....7
Зураг 4. 2025 оны 05 сарын 22-ны өдрийн байдлаар газрын харагдах байдал №1 .....7
Зураг 5. 2025 оны 05 сарын 22-ны өдрийн байдлаар газрын харагдах байдал №2 .....8
Зураг 6. 2025 оны 05 сарын 22-ны өдрийн байдлаар газрын харагдах байдал №3 .....8
Зураг 7. Тус газрын ерөнхий харагдах байдал №1  /2025.05.22/.....13
Зураг 8. Тус газрын ерөнхий харагдах байдал №2  /2025.05.22/.....13
Зураг 9. Тус газрын ерөнхий харагдах байдал №3  /2025.05.22/.....14
Зураг 10. Төслийн талбайн ерөнхий төрх.....19
Зураг 11. Хээрийн нөхцөлд ургамлан нөмрөгийн арви,тусгаг бүрхэвчийг тодорхойлох аргазүй .....21
Зураг 12. Төслийн талбайн ерөнхий төрх Бичиглэл-1 .....22

## *ФОТО ЗУРГИЙН ЖАГСААЛТ*

Фото зураг 1. Орчны хяналт шинжилгээ хийх ажлын явц (2025.05.22).....6
Фото зураг 2. DustTrak 8530 загварын зөөврийн багаж.....10
Фото зураг 3. EXTECH Noise Dosimeter, Datalogger, and Sound Level Meter SL355 загварын зөөврийн багаж .....10
Фото зураг 4.  . Уусан хүчилтөрөгч хэмжигч /DO-метр АН.84183.....24
Фото зураг 5.TDS, EC, T0C- хэмжигч багаж .....24
Фото зураг 6.Суурин pH метр .....24

# 1.УДИРТГАЛ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь Төсөл хэрэгжүүлэгч компанийн эзэмшлийн талбай, түүний үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

ОХШХ нь БОХТ-тэйгөө нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг төсөл хэрэгжүүлэгч хариуцах болно.

# 2. ТӨСЛИЙН БАЙРШИЛ

“Ахуй мандал” газрын тосны хаягдал бүтээгдэхүүн дахин боловсруулах үйлдвэр төслийн талбайн байршил нь Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 90 км, 1-р хорооны хүн амын суурьшлын бүсээс зүүн зүгт 2.3 км, 2-р хорооны суурьшлын бүсээс урд зүгт 2.4 км, засмал замаас 4.3 км зайд байрлана.




*Зураг 1. Төслийн байршлын зураг*




*Зураг 2. Төслийн талбайн агаар сансрын зураг*

## 3. УЛААНБААТАР ХОТЫН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НУТАГТ БАЙРЛАХ "АХУЙ МАНДАЛ" ДАХИВАР ҮЙЛДВЭР ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд үндсэн гүйцэтгэгч Улаанбаатар хотын Багахангай дүүргийн 1-р багийн нутагт байрлах ахуй мандал дахивар үйлдвэр төслийн байгаль орчны суурь үзүүлэлтүүдийг тодорхойлохын тулд Байгаль орчны хяналт судалгааг 2025 оны 05-р сарын 22 өдөр "Төгрөг Баян Хангай" ХХК хийж гүйцэтгэв.




*Фото зураг 1. Орчны хяналт шинжилгээ хийх ажлын явц (2025.05.22)*

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд агаар, ургамал, хөрсөн бүрхэвчинд хяналт шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Байгаль орчны хяналт, шинжилгээний ажлыг "Төгрөг баян хангай" ХХК-ийн судлаачдын баг ажиллалаа.

Багийн бүрэлдэхүүнд:

- Байгаль орчны мэргэжилтэн Г.Гэрэлмаа
- Агаарын шинжээч: Д.Сувд
- Хөрсний шинжээч А.Энхтөр
- Усны шинжээч: Р. Нацагдорж
- Хээрийн ажиглагч, дээж авагч: Б.Бадрах нар хийж гүйцэтгэлээ.




*Зураг 3. Төслийн талбайд хийгдсэн мониторингийн цэгийн байршлын зураг*



*Зураг 4. 2025 оны 05 сарын 22-ны өдрийн байдлаар газрын харагдах байдал №1*



*Зураг 5. 2025 оны 05 сарын 22-ны өдрийн байдлаар газрын харагдах байдал №2*



*Зураг 6. 2025 оны 05 сарын 22-ны өдрийн байдлаар газрын харагдах байдал №3*

# 3. Агаарын чанарын хяналт шинжилгээ

## 3.1 Судалгааны зорилго

"Ахуй мандал" дахивар үйлдвэрийн хөндлөнгийн мониторинг судалгаагаар агаарын чанарын хяналт шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорьсон.

## 3.2 Судалгааны байршил, хамрагдсан цэгүүд

*Хүснэгт 1. Агаарын чанарын хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил*

| Агаар | | Координат | Цэг сонгосон үндэслэл | Дээж авч буй фото зураг |
|---|---|---|---|---|
| 1 | 1-р цэг /Гадна талбай/ | 107°27'52.61"E 47°20'8.65"N | Өмнө болон дараа хийгдэх хяналт-шинжилгээний үр дүнтэй харьцуулах |  |
| 2 | 2-р цэг /Үйлдвэрийн дотор орчин/ | 107°27'48.94"E 47°20'8.18"N | | |

## 3.3 Судалгааны арга, дээж авалт

Төслийн талбайгаас агаарын хүхэрлэг хий (SO2), азотын давхар исэл (NO2), нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис) болон дуу шуугиан үзүүлэлт тус бүрийг хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнд тодорхойлов. Үүнд:

- ***Хүхэрлэг хий болон Азотын давхар исэл:*** Хүхэрлэг хий болон азотын давхар ислийг тодорхойлохдоо химийн шинжилгээний аргачлалаар тодорхойлсон.
  - *Хүхэрлэг хий:* Агаараас тетрахлормеркурат натрийн уусмал /ТХМ/-аар норгосон шингээгч гуурсанд 2 л/мин хурдтайгаар 20 минутын турш агаараас сорьц авч шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргад шингэсэн хүхэрлэг хийг лабораторийн нөхцөлд усан уусмалд шилжүүлж тэр уусмал дээрээ формальдегид, парарозаналины уусмал нэмэхэд үүссэн нэгдлийн өнгөний эрчимшлийг спектрофотометрээр хэмжин хүхэрлэг хийн агууламжийг тодорхойлов.
  - *Азотын давхар исэл:* Агаараас азотын давхар ислийг үл хатах мышьяклаг хүчлийн натрийн давс агуулсан кали иодын уусмалаар норгосон шингээгч гуурсаар 0.25 л/мин-ын хурдтайгаар 20 минутын турш соруулан сорьц авч шингээгч гуурсны шилэн бөмбөлгийн давхаргад шингээж лабораторийн нөхцөлд уусмалд шилжүүлж үүссэн нитрит ион сульфаналины хүчилтэй харилцан үйлчилж диазонэгдлийг үүсгэх бөгөөд тэр нь -нафтиламинтай урвалд орж азобудагч бодисыг уусмалын өнгөний эрчимжлээр азотын давхар ислийн хэмжээг тодорхойлов.

- ***Нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис):*** Төслийн талбай орчмын агаарт агуулагдах нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис)-ны агууламжийг DustTrak 8530 зөөврийн багажийн тусламжтай тодорхойлсон.
- ***Дуу чимээ:*** Шуугианы хэмжилтийг MNS 5003:2000 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага.” стандарт аргачлалын дагуу EXTECH Noise Dosimeter, Datalogger, and Sound Level Meter SL355) загварын зөөврийн багажаар тодорхойлсон.

### *3.3.1 Судалгаанд ашигласан багаж хэрэгсэл*



*Фото зураг 2. DustTrak 8530 загварын зөөврийн багаж*



*Фото зураг 3. EXTECH Noise Dosimeter, Datalogger, and Sound Level Meter SL355 загварын зөөврийн багаж*

## 3.4 Хяналт шинжилгээний үр дүн

### *3.4.1 Агаарын нийт тоосны хэмжилт*

Агаарын чанарын хяналтын 1-р цэгээс буюу үйлдвэрийн гадна талбайгаас авсан нийт тоосны хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас 1.06 дахин их давсан буюу тоосжилттой байна.

2-р цэг буюу үйлдвэрийн дотор орчноос авсан нийт тоосны хэмжээг MNS 4990:2015 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт илрээгүй хэвийн хэмжээнд байна.

*Хүснэгт 2. Нийт тоос / Нийт жинлэгдэгч бодис / хэмжилтийн үр дүн*

| № | Сорьц авсан цэг | Нийт тоос /Нийт жинлэгдэгч бодис/ | Нийт тоос /Нийт жинлэгдэгч бодис/ |
|---|---|---|---|
| | | 2025.05.22 | 2025.05.22 |
| 1 | 1-р цэг /Гадна талбай/ | 0.530 | 0.530 |
| **Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016 (20 минутын хэмжилт)** | | **0.500** | **0.500** |
| 2 | 2-р цэг /Үйлдвэрийн дотор орчин/ | 0.560 | 0.560 |
| **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015** | | **2** | **2** |

### *3.4.2 Агаарын бохирдуулагч бодисын хэмжилт*

Агаарын чанарын хяналтын цэгээс авсан хүхэрлэг хий болон азотын давхар ислийн хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага”, MNS 4990:2015 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт илрээгүй хэвийн хэмжээнд байна.

*Хүснэгт 3. Агаарын бохирдуулагч бодисын хэмжилтийн үр дүн*

| № | Сорьц авсан цэг | $NO_2$ (*Азотын давхар исэл мг/м$^3$*) | $SO_2$ (*Хүхэрлэг хий мг/м$^3$* ) | $NO_2$ (*Азотын давхар исэл мг/м$^3$*) | $SO_2$ (*Хүхэрлэг хий мг/м$^3$* ) |
|---|---|---|---|---|---|
| | | 2025.05.22 | | 2025.05.22 | |
| 1 | 1-р цэг /Гадна талбай/ | 0.048 | 0.012 | 0.021 | 0.009 |
| **Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016 (20 минутын хэмжилт)** | | **0.200** | **0.450** | **0.200** | **0.450** |
| 2 | 2-р цэг /Үйлдвэрийн дотор орчин/ | 0.028 | 0.014 | 0.028 | 0.014 |
| **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015** | | **2** | **2** | **2** | **2** |

### *4.3.3 Дуу шуугианы хэмжилт*

Дуу шуугианы үзүүлэлтийг хяналтын цэгийн ойр орчимд хэмжсэн ба 16 цагийн дундаж үр дүнг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага”, MNS 4990:2015 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага” стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт илрээгүй, хэвийн хэмжээнд байна.

*Хүснэгт 4. Дуу шуугианы хэмжилтийн үр дүн*

| № | Сорьц авсан цэг | Дуу чимээ дБ (А) | Дуу чимээ дБ (А) |
|---|---|---|---|
| | | 2025.05.22 | 2025.05.22 |
| 1 | 1-р цэг /Гадна талбай/ | 48 | 48 |
| **Агаарын чанарын стандарт MNS 4585: 2016 (20 минутын хэмжилт)** | | 60 | 60 |
| 2 | 2-р цэг /Үйлдвэрийн дотор орчин/ | 66 | 66 |
| **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015** | | 85 | 85 |

## 3.5 Дүгнэлт, зөвлөмж

“Ахуй мандал” дахивар үйлдвэрийн агаарын судалгааны 1 болон 2-р цэгээс агаарын хүхэрлэг хий (SO2), азотын давхар исэл (NO2), нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис) болон дуу шуугиан хэмжилт хийж гарсан үр дүн тус бүрийг MNS 4585:2016 стандарт болон MNS

4990:2015 стандарттай харьцуулахад хүхэрлэг хий (SO2), азотын давхар исэл (NO2) нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт илрээгүй, хэвийн хэмжээнд байна.

Агаар дахь нийт тоосны хэмжээ үйлдвэрийн гадна талбайд MNS 4585:2016 стандартын хүлцэх хэмжээнээс 1.06 дахин их байгаа нь тоосжилттой байгааг харуулж байна. Иймд тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх, тоос дарагч бодис хэрэглэх, зам талбайн хучилтыг сайжруулах зэрэг инженерийн арга хэмжээ авах шаардлагатай. Харин үйлдвэрийн дотор орчны нийт тоосны хэмжээ MNS 4990:2015 стандартын хүлцэх түвшинд байгаа нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцэж байна. Гэсэн ч ажлын байрны агаарын чанарыг тогтмол хянаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь зүйтэй.

Төслийн талбайд авсан дуу шуугианы хэмжилтийн 16 цагийн дундаж түвшин зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байна.

Шуугиан гэж янз бүрийн давтамжтай өндөр, нам авианы замбараагүй хослолыг хэлнэ. ДЭМБ-аас гаргасан судалгаагаар шуугианы шалтгаантай сонсгол бууралт нь дэлхийд хамгийн түгээмэл тохиолддог, урьдчилан сэргийлэх боломжтой мэргэжлээс шалтгаалсан өвчний нэг гэж үздэг [12].

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн талбайд ногоон байгууламж хувь хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай учир нь модлог ургамал дуу чимээний бохирдлыг бууруулаад зогсохгүй орчны агаарыг цэвэршүүлэх ач холбогдолтой. Зайлшгүй шаардлагатай биш бол машины дуут дохиог хэрэглэхгүй байхыг ажилчдад анхааруулах.

# 4. Хөрсний хяналт шинжилгээ

## 4.1 **Судалгааны зорилго**

“Ахуй мандал” дахивар үйлдвэр төслийн хөндлөнгийн мониторинг судалгаагаар хөрсний доройтол, бохирдол, төрөл зэрэглэлийг тогтоож хяналт шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорьсон.



*Зураг 7. Тус газрын ерөнхий харагдах байдал №1 /2025.05.22/*



*Зураг 8. Тус газрын ерөнхий харагдах байдал №2 /2025.05.22/*



*Зураг 9. Тус газрын ерөнхий харагдах байдал №3 /2025.05.22/*

## 4.2 Судалгааны байршил

*Хүснэгт 5. Хөрсний хяналт шинжилгээ хийсэн цэгийн байршил*

| Хөрс | | Координат | Цэг сонгосон үндэслэл | Дээж авч буй фото зураг |
|---|---|---|---|---|
| 1 | Зүсэлт-1<br>2025.05.22 | 107°27'51.00"E<br>47°19'45.00"N | Өмнө хийгдсэн хяналт-шинжилгээний үр дүнтэй харьцуулах |  |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | Зүсэлт-2<br>2025.05.22 | 107°27'48.00"E<br>47°20'8.00"N | |  |
| 3 | Зүсэлт-3<br>2025.05.22 | 107°27'53.00"E<br>47°20'11.00"N | |  |

### 4.3 Судалгааны арга, дээж авалт

Хөрсний дээжийг авахдаа MNS 3298:1990 "Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага стандартыг мөрдлөг болгон ажилласан.

Хөрсний 3 зүсэлт хийж агрохими, механик бүрэлдэхүүн, хүнд металл, хөрсний эрүүл ахуйн дээжийг "Нарт Шүүн Консалтинг" ХХК-ийн хөрсний итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв. Шинжилгээ хийсэн лабораторийн арга зүйг Хүснэгт 6-т харуулав.

*Хүснэгт 6. Бодис тодорхойлох аргууд*

| Тодорхойлох бодисын нэр | Хэмжилт хийсэн арга | Аргазүйн нарийвчлал |
|---|---|---|
| Ялзмаг | И.В. Тюрин | <0.04 мг/100 г хөрс |
| Хөрсний урвалын орчин | pH-метр | <0.2 |
| Хөдөлгөөнт фосфор | Мачигин | <0.05 мг/100 г хөрс |
| Хөдөлгөөнт кали | Дөлийн фотометрийн | <0.05 мг/100 г хөрс |
| Хөрсний шингээх цогц | Трилон Б. | <0.2% |
| Карбонат | Кальци метрийн | <0.5% |
| Механик бүрэлдэхүүн | Качинскийн арга | <0.5% |
| Хөрсний хүнд металл | Атом шингээлтийн спектрометр | 0.005-10.0<br>0.001-10.0 |

***Хяналт-шинжилгээний үр дүн***

*Хүснэгт 7. Хөрсний механик бүрэлдэхүүн*

| № | Дээжний нэр | Гүн, см | Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | Зүсэлт-1 | 0-30 | 3.1 | 57.2 | 20.1 | 8.7 | 5.0 | 5.9 | 19.6 |
| 2 | Зүсэлт-2 | 0-20 | 3.7 | 58.0 | 18.2 | 10.6 | 4.1 | 5.4 | 20.1 |
| 3 | Зүсэлт-3 | 0-20 | 4.9 | 58.0 | 17.2 | 9.4 | 3.2 | 7.3 | 19.9 |

Хөрсний шинжилгээний дүнгээр физик шаврын хэмжээгээр элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

*Хүснэгт 8. Хөрсний химийн задлан шинжилгээний дүн*

| № | Дээжний нэр | Гүн см | pH | Давс % | ЦДЧ | $CaCO_3$ % | Ялзмаг % | $NO_3$ мг/100г | Шингээгдсэн сууриуд мг-экв/100 гр | | | Шим тэжээлийн элементүүд мг/100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Ca+Mg | Ca | mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 1 | Зүсэлт-1 | 0-30 | 7.80 | 0.060 | 0.142 | 2.28 | 1.98 | 0.53 | 27 | 14 | 12 | 4.3 | 10 |
| 2 | Зүсэлт-2 | 0-20 | 7.88 | 0.065 | 0.154 | 1.14 | 1.84 | 0.58 | 23 | 13 | 10 | 3.9 | 14 |
| 3 | Зүсэлт-3 | 0-20 | 7.97 | 0.056 | 0.133 | 0.96 | 2.08 | 0.49 | 23 | 14 | 9 | 4.2 | 14 |

Хөрсний үржил шимт үе давхаргын үзүүлэлтийг 0-20см /Хагас зүсэлт/ гүнээс дээж авч тодорхойлов. Урвалын орчин сул шүлтлэг, ялзмагийн агууламж бага, цахилгаан дамжуулах чанар маш бага буюу чадваргүй, шингээгдсэн сууриудаас Са хангалттай, Mg маш их, хялбар уусах давсны агууламж маш бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфорын хангамж, калийн агууламж маш бага байна. Хөрсний үржил шимийн түвшин бага байна.

*<u>Хөрсний бохирдол</u>*

“Төгрөг Баян Хангай” ХХК-ийн 2025 оны 05 дугаар сарын 22-ны хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүнг MNS 5850:2019 “Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандарттай харьцуулахад Зүсэлт-1 болон Зүсэлт-2-аас авсан хөрсний дээж хүлцэх агууламж болон хортой, аюултай агууламжаас бага буюу дээж авсан хэсгийн хөрсөнд бохирдол илрээгүй байна.

Зүсэлт-2 хийсэн хөрсний хүнд металлын дээжээс хром хүлцэх агууламжаас бага зэрэг давсан буюу хөрс бага зэрэг бохирдолтой байна. Хүнд металл нь хүнд хүнсээр ба агаараар дамжин хуримтлагдана. Иймд төсөл хэрэгжүүлэгч нь хөрсөнд агуулагдах хромын хэмжээг тогтмол хянаж байх зорилгоор улирал бүр хөрсний дээж авч хүнд металлын шинжилгээ хийлгэж байх шаардлагатай. Хүлцэх агууламжаас давсан хортой агууламжтай хөрсийг эзэлхүүн (м3)-ээр нь хуулан авч аюултай хог хаягдал устгах мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр Хог хаягдлын тухай хуулийн 5-р бүлэг. Аюултай хог хаягдлыг савлах, түр хадгалах, тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах шаардлага болон 34 дүгээр зүйл. Аюултай хог хаягдлыг ландфиллд булшилж устгахад

тавигдах нэмэлт шаардлага тус тус холбогдох хуулийн дагуу орон нутгаас зөвшөөрөлтэй аюултай хог хаягдал хаядаг газар луу мэргэжлийн байгууллага зөөвөрлөж аюулгүй байдлыг хангах;

*Хүснэгт 9. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж*

| № | Элемент | Зүсэлт-1 | Зүсэлт-2 | Зүсэлт-3 | **Зөвшөөрөгдөх дээд хэмжээ (MNS 5850:2019)** |
|---|---|---|---|---|---|
| | | 2025.05.22 | 2025.05.22 | 2025.05.22 | |
| 1 | Cr | 52.2 | 61.3 | 46.2 | **60** |
| 2 | Pb | 19.3 | 24.3 | 21.8 | **50** |
| 3 | Cd | 0.0 | 0.0 | 0.0 | **1** |
| 4 | Zn | 9.5 | 40.4 | 5.7 | **100** |
| 5 | Cu | 10.0 | 12.0 | 10.3 | **60** |
| 6 | Ni | 3.4 | 13.0 | 9.5 | **60** |

*Хүснэгт 10. Хөрсөн дэх эрүүл ахуйн шинжилгээ*

| № | Дээжний нэр | Нянгийн тоо MNS 63416:2012 | Гэдэсний савханцарын титр MNS 5367:2004 | | Анаэробын MNS 6341:2012 | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Шинжилгээний хариу | Шинжилгээний хариу | Бохирдлын зэрэг | Шинжилгээний хариу | Бохирдлын зэрэг |
| 1 | Зүсэлт-1 | $7.1*10^5$ | ≥ 0.1 | 1 | ≥ 0.1 | 1 |

Төслийн талбайн хөрсөн дэхь Зүсэлт-1-т хийсэн хөрсний эрүүл ахуйн шинжилгээгээр холбогдох стандартуудтай харьцуулахад бохирдол багатай байна.

### 4.4 Дүгнэлт

Хөрсний шинжилгээний дүнгээр физик шаврын хэмжээгээр элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.

Хөрсний үржил шимт үе давхаргын үзүүлэлтийг 0-20см /Хагас зүсэлт/ гүнээс дээж авч тодорхойлов. Урвалын орчин сул шүлтлэг, ялзмагийн агууламж бага, цахилгаан дамжуулах чанар маш бага буюу чадваргүй, шингээгдсэн сууриудаас Са хангалттай, Mg маш их, хялбар уусах давсны агууламж маш бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфорын хангамж, калийн агууламж маш бага байна. Хөрсний үржил шимийн түвшин бага байна.

"Төгрөг Баян Хангай" ХХК-ийн 2025 оны 05 дугаар сарын 22-ны хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүнг MNS 5850:2019 "Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ" стандарттай харьцуулахад Зүсэлт-1 болон Зүсэлт-2-оос авсан хөрсний дээж хүлцэх агууламж болон хортой, аюултай агууламжаас бага буюу хөрсөнд бохирдол илрээгүй байна. Зүсэлт-2 хийсэн хөрсний хүнд металлын дээжээс хром хүлцэх агууламжаас давсан буюу хөрс бохирдолтой байна.

Төслийн талбайн хөрсөн дэхь Зүсэлт-1-т хийсэн хөрсний эрүүл ахуйн шинжилгээгээр холбогдох стандартуудтай харьцуулахад бохирдол багатай байна.

### 4.5 Зөвлөмж:

- Төслийн автомашины зогсоол болон байнгын хөдөлгөөнтэй хэсэгт хатуу хучилттай зам талбай байгуулж, замын чиглэл болон зогсоолыг тодорхой тэмдэг

тэмдэглэгээтэй болгох нь зүйтэй. Ингэснээр шороон замын тоосжилт, хөрс нягтралт, олон салаа зам үүсэх зэрэг сөрөг үзэгдлүүдээс сэргийлнэ.

- Олон салаа зам гаргах, зөвшөөрөлгүй газар зорчихоос сэргийлэх үүднээс зам, чиглэлийг заасан тэмдэг тэмдэглэгээг тодорхой байрлуулах шаардлагатай.
- Хүлцэх агууламжаас давсан хортой агууламжтай хөрсийг эзэлхүүн (м3)-ээр нь хуулан авч аюултай хог хаягдал устгах мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр Хог хаягдлын тухай хуулийн 5-р бүлэг. Аюултай хог хаягдлыг савлах, түр хадгалах, тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах шаардлага болон 34 дүгээр зүйл. Аюултай хог хаягдлыг ландфиллд булшилж устгахад тавигдах нэмэлт шаардлага тус тус холбогдох хуулийн дагуу орон нутгаас зөвшөөрөлтэй аюултай хог хаягдал хаядаг газар луу мэргэжлийн байгууллага зөөвөрлөж аюулгүй байдлыг хангах;
- Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 10 дугаар зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэгт заасны дагуу хог хаягдлаа ангилан ялгах, зориулалтын сав байрлуулах, хог хаягдлын цэгийг тохижуулах, хог хаягдлаа шатаахгүй байх шаардлагатай. Төсөл хэрэгжүүлэгч нь энгийн хог хаягдлыг орон нутгийн ТҮК-тэй хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээг жил бүр сунган ажиллах, аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн компанитай байгуулсан аюултай хог хаягдлыг ачиж, тээвэрлэх, устгуулах гэрээг жил бүр сунган ажиллах шаардлагатай.

# 5. УРГАМЛАН НӨМРӨГИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

## *5.1 Судалгааны зорилго*

“Ахуй мандал” дахивар үйлдвэр төслийн мониторинг судалгаагаар ургамлан бүрхэвчийн доройтол, бохирдол, төрөл зэрэглэлийг тогтоож хяналт шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорьсон.



*Зураг 10. Төслийн талбайн ерөнхий төрх*

## *5.2. Судалгааны материал аргазүй*

Бидний судалгаа явуулсан цаг хугацаа нь ургамлын төрөл зүйл үндсэндээ тайван байдалд шилжиж байсан үе тохиосон. Төсөл хэрэгжих газрын ургамалжлын төлөв байдлыг тогтоох зорилгоор газрын гадаргуу, хөрсний төрлийг анхаарч ургамлын аймаг, ургамалжлын төлөв байдлыг дараах судалгааны аргаар судлав. Үүнд:

- Судалгааны талбай сонгох. Уламжлалт нүдэн баримжааны аргаар бичиглэл үйлдэх, талбайг тухайн бүс нутгийн ургамалжилтын хэв шинжийг бүрэн илэрхийлж чадахуйц, газрын гадарга нэгэн жигд байхаар сонгоно. Суурь зураг дээр хөрс судлаачидтай судалгааны ажлаа төлөвлөж, судалгааны талбайд хөндлөн ба уртааш зүсэг хийж болно.

- Геоботаникийн дэлгэрэнгүй бичиглэл үйлдэх. Ургамлан нөмрөгийн төрх байдлыг тогтоохын тулд судалгааны цэгүүдийг сонгон геоботаникийн дэлгэрэнгүй бичиглэлийг тусгай зориулалтын бланк дээр үйлдэнэ. Үүнд эхлээд ургамлын зүйл тус бүрийн арви, бүрхэц, нүдэн баримжаагаар үржлийн ба ургал найлзуурын өндрийг тэмдэглэхээс гадна үзэгдэл зүйн ямар үе шатанд байгааг тодорхой бичнэ. Бичиглэл хийх судалгааны талбай 1х1, 10х10 $м^2$ хэмжээтэй байх ба газрын нэр бүлгэмдлийн хэв шинж, тусгагын бүрхэц, хөрсний төрөл хайрга чулуу, элсэн бүрхэвчийн эзлэх хувь зэргийг бичнэ (Хүснэгт 11).

*Хүснэгт 11. Ургамлын судалгаа шинжилгээний аргууд*

| ***д/д*** | ***Судалгааны үзүүлэлтүүд*** | ***Судалгаа шинжилгээний арга*** |
|---|---|---|
| ***1*** | *Ургамлын арви,тусгагийн бүрхэц* | *Друде (1913)-гийн нүдэн баримжааны арга (soc-100%, $cop_3$50-100%,$cop_2$25-50%, $cop_1$ 10-25%, sparsae1-10%, sol 0.1-1%)* |
| ***2*** | *Ургамлын зүйлийн бүрдэл* | *Ургамлын зүйлийг Грубов (1982)-ын таних бичиг-ээр тодорхойлно* |
| ***3*** | *Ургамлын зүйлийн статус* | *Тухайн зүйлийн ховор, эндемизм, үлдвэр эсэх г.м. статусыг Өлзийхутаг, 1989; Байгалийн ургамлын тухай хууль,1995, МУ-ын Улаан ном,1987,1997,2013; Бүс нутгийн Улаан Данс,2012;* |
| ***4*** | *Ургамлан нөмрөгийн талхагдлын зэрэг* | *Талхагдлын зэрэглэлийг илтгүүр зүйлээр тогтоох Гунин,Востокова нарын аргачилсан зөвлөмж, 1989; Цэрэнбалжид, 2002* |

**Судалгааны материал**. Хээрийн судалгааг 2025 оны 05-р сарын 22-ний өдөр гүйцэтгэв. Төслийн талбай байрлах нөлөөллийн бүсэд ажиглалт судалгааг явуулж, фото зураг, солбицол авч баталгаажуулав.

**Ургамлын бүрхэвчийн арга зүй**

- ***Зүйлийн бүрэлдэхүүн***: Ургамалжлын зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо зүйл тус бүрийг флорын баялаг тодорхойлох аргаар бүртгэж, зүйлийн латин, Монгол нэрийг И.В.Грубовын (1982) бүтээлд зааснаар тус тус нэрлэсэн.
- ***Арви***: Ургамалжлын зүйлийн арвийг О. Друдегийн нүдэн баримжааны аргаар үнэлгээг өгсөн.
- ***Тусгаг бүрхэц***: Ургамалжлын зүйлийн тусгаг бүрхцийг Раменскийн 1$м^2$-ийн хэмжээст тороор тодорхойлсон.
- ***Өсөлт***: Ургамлын өсөлтийг тодорхойлохын тулд өндрийг сантиметрийн хэмжээст шугамаар газрын хөрснөөс дээш 0 см-ийн өндөрт хэмжсэн.

**Ургамлын тусгаг бүрхэвчийг тодорхойлох арга**

Ургамлын бүрхцийг тодорхойлохдоо Раменскийн тор ашиглана. Хээрийн судалгааны үед 1м$^2$ талбайг санамсаргүй аргаар сонгон авч тусгаг бүрхэц буюу ургамлын бүх эрхтний дээд хэсэг болон хагд өвсний газрын гадаргууг бүрхсэн талбайг эгц дээрээс харж нийт талбайг 100 хувь гэж харьцуулан тооцсон.

О. Друде /1913/ гаргасан зүйлийн газрын гадаргуу дах зүйлийн бодгалийн тоо-арвийг нүдэн баримжаагаар тооцох шатлалын аргыг ашиглана тодорхойлсон. Мөн зүйлийн бүрэлдэхүүнийг 10х10 м$^2$ талбайд ургасан ургамлын зүйл тус бүрийг таньж тодорхойлон бүрхцийг хувиар жагсааж бланканд бичсэн.



*Зураг 11. Хээрийн нөхцөлд ургамлан нөмрөгийн арви,тусгаг бүрхэвчийг тодорхойлох аргазүй*

**Биомассын дээжлэлт:** Биомассын дээжийг үйл ажиллагааны бүлгээр авсан. Дээжийг зориулалтын цаасан уутанд хийж, 80 $^0$C-ийн хатаах шүүгээнд 24 цаг хатаасны дараа, зууны нарийвчлал бүхий электрон жингээр жинлэсэн.

Судалгааны талбайд тэмдэглэгдсэн ургамлын зүйлүүдийг В. И. Грубов. (2007). Монголын гуурст ургамал таних бичиг болон Монголын бэлчээрийн менежментийн холбоо (2011). Монгол орны гуурст дээд ургамлын хураангуйлсан нэрийн жагсаалт зэрэг ургамал тодорхойлох бичгийг ашиглан овог, төрлөөр ангилан тодорхойлов.

### 5.3 Судалгааны үр дүн

Уг төслийн талбай нь ургамал газарзүйн тойргоор Монгол дагуурын уулын ойт хээрийн тойрогт хамаарагдана. Энд 946 зүйл гуурст дээд ургамал ургадаг.

Төслийн талбай орчмын ургамал нөмрөг маш эмзэг. Машин техникийн болон хүний нөлөөгөөр ургамал нөмрөг үндсэн төрхөө алдаж, бүрдэл нь цөөрч, бүрхэц нь сийрэгжсэнээс хөрс гэмтэх, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг шарилжны төрлийн хог ургамал давамгайлах магадлал ихтэй байна.

Судалгааны талбайд Бүйлэс үхэр харгана бэлчээрийн төрөл тархсан байна. Үүнд:

**Бүйлэс үхэр харганат бүлгэмдэл:** Том цэцэгт даагансүүл (*Koeleria macrantha*), сунагар биелэг (*Poa attenuata*) ургасан байна. Мөн *(Agropyron cristatum), (Stipa krylovii)* зонхилон ургасан байна. Сөөгнөөс (*Amygdalus pedunculata*), *Spiraea aquilegiifolia, Caragana bungei, C.microphylla, C.pugmaea, C.srenophylla* зэрэг ургасан байна. Заримдаг сөөгөнцөрөөс (*Artemisia frigida*) байнга тааралдсан. Улалжийн *(Carex duriuscula),* (*C.korshinskyi*) ургасан байна . Алаг өвснөөс *Aster alpinus, Eremogone,capillaris, Filifolium sibiricum* зэрэг ургасан байна. Цөөн наст ургамлаас *Aster hispidus, Orostachys spinosa* тааралдсан. 10 м$^2$ дахь зүйлийн тоо 9-16, 1 м$^2$ дахь зүйлийн тоо 2-4, ургамлын ерөнхий тусгаг бүрхэц 55-60%, ургамлын дундаж өндөр 5-20 см, ургамлын дундаж ургац 1.9 цн/га байна.



*Зураг 12. Төслийн талбайн ерөнхий төрх Бичиглэл-1*

### 5.4 Зөвлөмж

Төсөл хэрэгжүүлэгч талаас ногоон байгууламж бүхий мод сөөг ургуулж, арчлах шаардлагатай байна.

Манай оронд шарилж лууль болон бусад хөл газрын ургамлын цэцгийн тоосны шалтгаант харшил 7, 8, 9-р саруудад ихээр тохиолддог. Ургамлын цэцэглэж дохиурын тоосовч задарч тоосоо гүвэх үед салхиар тарсан 10-35 микрон хэмжээтэй тоосны мөхлөгүүд агаарын 1 см$^2$ талбайд 50-аас дээш тархсан үед амьсгалын зам арьсны салстыг хэт мэдрэгшүүлж харшил үүсгэх нөхцөл шалтгаан болдог. Иймд ургамлын тоосны харшилтай ажилчид доорх зүйлсийг анхаарч ажиллах шаардлагатай. Үүнд

- Шарилж, лууль нь өглөөний 04:00-09:00, оройн 17:00-22:00 цагт тоосоо гөвдөг. Энэ үед хаалга цонхоо онгойлгохгүй байх эсвэл тор байршуулах;
- Машин болон ажлын байранд агаар цэвэршүүлэгч хэрэглэх;

- Гадуур өмсөж явсан хувцсаа битүү орчинд /шүүгээ, уут/ хийх;
- Гадаа ажиллаж байх хугацаанд амны хаалт зүүх;
- Ургамалтай ажиллах шаардлага гарвал амны хаалт хэрэглэх;

Мөн шарилж, луулийн хадалт, тайралтыг 3 үе шаттайгаар хийх: Үүнд

- Эхний тайралт: 10 см өндөр ургасан үед тайрах;
- Хоёрдугаар тайралт: 1-2 удаа давтан тайрах;

Гуравдугаар тайралт: 2-3 удаа давтан тайрах;

- Эвдэрсэн газрыг зохих стандартын дагуу хэлбэржүүлж, нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэх
- Машин, өөрөө явагч хэрэгслийн хөдөлгөөн, нөлөөллийг тухайн тогтоогдсон зурваст байлгах арга хэмжээ авах

# 6. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

## 3.1 Судалгааны зорилго

Мониторинг судалгаагаар унд ахуйн худгийн уснаас мониторингийн судалгаа шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөх зорилготой.

## 3.2 Судалгааны арга зүй

Усны дээжийг 24 цагийн дотор лабораторид хүргүүлсэн. Усны дээжийг зориулалтын аргаар ариутгасан шил болон 1 литрийн багтаамжтай хуванцар саванд авсан. Энэхүү хуванцар сав нь их концентрацитай бодис бүхий дээж хадгалаагүй худалдааны цэвэршүүлсэн цэвэр усны хуванцар сав юм. Усны дээж авахдаа савыг дүүргэн авч саванд агаар байх зайгүйгээр тагласан. Энэ нь тээвэрлэлтийн үед сэгсрэгдэх, хийнүүдийн хоорондох харилцан үйлчлэлийг хязгаарлах ач холбогдолтой.

Усны хяналт шинжилгээний ажлын хүрээнд усны ерөнхий химийн үзүүлэлтийг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын төв лабораторид, микробиологи болон хүнд металлын үзүүлэлтийг “Нарт шүүн консалтинг” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид тус бүр шинжлүүлсэн.

- Усны ерөнхий химийн шинжилгээгээр химийн үзүүлэлтүүд (анион, катион, ерөнхий хатуулаг, pH, цахилгаан дамжуулах чанар, нийт ууссан эрдэс давс, Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, Умбуур бодис, Химийн хэрэгцээт хүчилтөрөгч), физикийн үзүүлэлтүүд (тунгалаг, өнгө, үнэр, амт, тунадасжилт)-ийг шинжлүүлэв. Микробиологийн үзүүлэлтүүдээс: *Clostridium perfringens*, Бактерийн ерөнхий тоо, Гэдэсний бүлгийн нян, Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян зэрэг үзүүлэлтүүдийг шинжлүүлэв.
- Хүнд металлын шинжилгээгээр Cr (VI), Al, Cd, Cr, Fe, Pb, Zn зэрэг зарим хүнд металлын элементүүдийг шинжлүүлэв.
- Усны ерөнхий химийн шинжилгээг эзлэхүүн болон жинлэлтийн аргыг ашиглаж хийж гүйцэтгэсэн байна.
- Микробиологийн шинжилгээг MNS 5668-2006, MNS (ISO) 19250: 2017 стандарт аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн байна.

## 3.3 Судалгаанд ашигласан багаж, тоног төхөөрөмж




*Фото зураг 4. . Ууссан хүчилтөрөгч хэмжигч /DO-метр AH.84183*




*Фото зураг 5.TDS, EC, T0C-хэмжигч багаж*




*Фото зураг 6.Суурин pH метр*

### 3.4 Усны хяналт-шинжилгээний үр дүн

*Ерөнхий химийн шинжилгээ*

*Хүснэгт 12. Худгийн усны ерөнхий химийн шинжилгээ*

| Катион | 1дм$^3$ | | | Анион | 1дм$^3$ | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Мг/л | Мг-экв/л | Мг-экв/% | | Мг/л | Мг-экв/л | Мг-экв/% |
| $Ca^{++}$ | 66.00 | 3.29 | 74.80 | $CO_3^{--}$ | 0.00 | 0.00 | 0.00 |
| $Mg^{++}$ | 10.00 | 0.82 | 18.69 | $HCo_3^{--}$ | 156.00 | 2.56 | 58.07 |
| $Fe^{++}$ | 0.00 | 0.00 | 0.00 | $CI^{--}$ | 36.00 | 1.02 | 23.07 |
| $K^{+}$ | 1.00 | 0.03 | 0.58 | $SO_4^{--}$ | 36.00 | 0.75 | 17.04 |
| $Na^{+}$ | 6.00 | 0.26 | 5.93 | $NO_3^{--}$ | 5.00 | 0.08 | 1.83 |
| Дүн | 83.00 | 4.40 | 100.00 | Дүн | 233.00 | 4.40 | 100.00 |

Худгийн усанд хийсэн ерөнхий химийн шинжилгээний үр дүнг MNS1097:1970 стандарттай харьцуулан гаргав. Химийн бүрэлдэхүүн нь гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, 2-р төрлийн цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, бага хатуулагтай ус юм.

*Эрүүл ахуйн шинжилгээ*

*Хүснэгт 13. Худгийн усны эрүүл ахуйн шинжилгээний дүн, 1 мл усанд*

| № | Дээжийн нэр | Нянгийн тоо | Гэдэсний савханцрын титр (E.coli) | Анаэробын (Cl.perfringens) |
|---|---|---|---|---|
| | | Шинжилгээний хариу | Шинжилгээний хариу | Шинжилгээний хариу |
| 1 | Худаг | 7 | Илрээгүй | Илрээгүй |

Худгийн усны шинжилгээний дүн MNS 0900:2018 стандартад бүрэн нийцэж, ундны зориулалтаар хэрэглэхэд тохиромжтой, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

*Хүнд металлын шинжилгээ*

*Хүснэгт 14. Худгийн усны хүнд металлын үзүүлэлт*

| № | Дээжний нэр | Агууламж мг/л | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Ni /никель/ | Cd /Кадми/ | Pb /Хартугалга/ | Zn /Цайр/ | Cr /Хром/ | Cu /Зэс/ |
| 1 | Худаг | 0.0 | 0.0 | 0.0 | 0.33 | 0.0 | 0.014 |
| **Зөвшөөрөгдөх дээд хэмжээ / MNS 0900:2018/** | | 0.07 | 0.03 | 0.1 | 5.0 | 0.05 | 1.0 |

Худгийн усны шинжилгээний дүн MNS 0900:2018 стандартад бүрэн нийцэж, ундны зориулалтаар хэрэглэхэд тохиромжтой, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

### 3.5 Дүгнэлт, зөвлөмж

- Худгийн усанд хийсэн ерөнхий химийн шинжилгээний үр дүнг MNS1097:1970 стандартад харьцуулан гаргав. Химийн бүрэлдэхүүн нь гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, 2-р төрлийн цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, бага хатуулагтай ус юм.

- Худгийн усны шинжилгээний дүн MNS 0900:2018 стандартад бүрэн нийцэж, ундны зориулалтаар хэрэглэхэд тохиромжтой, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.
- Худгийн усны шинжилгээний дүн MNS 0900:2018 стандартад бүрэн нийцэж, ундны зориулалтаар хэрэглэхэд тохиромжтой, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

Худгийн усны химийн найрлага, эрүүл ахуйн үзүүлэлтүүд нь MNS 1097:1970 болон MNS 900:2018 стандартын шаардлагад бүрэн нийцэж байгаа тул ундны зориулалтаар хэрэглэхэд тохиромжтой гэж үзнэ. Цаашид усны чанарыг хадгалах зорилгоор худгийн эргэн тойрны хамгаалалтын бүсийг хэвийн байлгах, бохирдол үүсгэх хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, усны чанарт улирал тутам хяналт-шинжилгээ хийхийг зөвлөж байна. Мөн усыг хүнсэнд хэрэглэхийн өмнө энгийн шүүлтүүрээр шүүн хэрэглэх нь илүү эрүүл ахуйн хувьд үр дүнтэй байж болно.

# 7. ТАЙЛАНГИЙН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

“Ахуй мандал” дахивар үйлдвэр төслийн байгаль орчны мониторингийн тайлангийн хээрийн болон лабораторийн шинжилгээний үр дүнд бид дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- 2025 оны 05 сарын 22-ны өдрийн байдлаар судалгаа хийхэд газрын хувьд антропогены хүчин зүйлийн улмаас хөрс болон ургамал дунд зэрэг талхлагдсан байна.
- “Ахуй мандал” дахивар үйлдвэрийн агаарын судалгааны 1 болон 2-р цэгээс агаарын хүхэрлэг хий (SO2), азотын давхар исэл (NO2), нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис) болон дуу шуугиан хэмжилт хийж гарсан үр дүн тус бүрийг MNS 4585:2016 стандарт болон MNS 4990:2015 стандарттай харьцуулахад хүхэрлэг хий (SO2), азотын давхар исэл (NO2) нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт илрээгүй, хэвийн хэмжээнд байна.
- Агаар дахь нийт тоосны хэмжээ үйлдвэрийн гадна талбайд MNS 4585:2016 стандартын хүлцэх хэмжээнээс 1.06 дахин их байгаа нь тоосжилттой байна.
- Төслийн талбайд авсан дуу шуугианы хэмжилтийн 16 цагийн дундаж түвшин зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байна.
- Хөрсний шинжилгээний дүнгээр физик шаврын хэмжээгээр элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй байна.
- Хөрсний үржил шимт үе давхаргын үзүүлэлтийг 0-20см /Хагас зүсэлт/ гүнээс дээж авч тодорхойлов. Урвалын орчин сул шүлтлэг, ялзмагийн агууламж бага, цахилгаан дамжуулах чанар маш бага буюу чадваргүй, шингээгдсэн сууриудаас Са хангалттай, Mg маш их, хялбар уусах давсны агууламж маш бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфорын хангамж, калийн агууламж маш бага байна. Хөрсний үржил шимийн түвшин бага байна.
- “Төгрөг Баян Хангай” ХХК-ийн 2025 оны 05 дугаар сарын 22-ны хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүнг MNS 5850:2019 “Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандарттай харьцуулахад Зүсэлт-1 болон Зүсэлт-3-аас авсан хөрсний дээж хүлцэх агууламж болон хортой, аюултай агууламжаас бага буюу хөрсөнд бохирдол илрээгүй байна. Зүсэлт-2 хийсэн хөрсний хүнд металлын дээжээс хром хүлцэх агууламжаас давсан буюу хөрс бохирдолтой байна.
- Төслийн талбайн хөрсөн дэхь Зүсэлт-1-т хийсэн хөрсний эрүүл ахуйн шинжилгээгээр холбогдох стандартуудтай харьцуулахад бохирдол багатай байна.
- Төслийн талбай орчмын ургамал нөмрөг маш эмзэг. Машин техникийн болон хүний нөлөөгөөр ургамал нөмрөг үндсэн төрхөө алдаж, бүрдэл нь цөөрч, бүрхэц нь сийрэгжсэнээс хөрс гэмтэх, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг шарилжны төрлийн хог ургамал давамгайлах магадлал ихтэй байна.
- Худгийн усанд хийсэн ерөнхий химийн шинжилгээний үр дүнг MNS1097:1970 стандартад харьцуулан гаргав. Химийн бүрэлдэхүүн нь гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, 2-р төрлийн цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, бага хатуулагтай ус юм.

- Худгийн усны шинжилгээний дүн MNS 0900:2018 стандартад бүрэн нийцэж, ундны зориулалтаар хэрэглэхэд тохиромжтой, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.
- Худгийн усны шинжилгээний дүн MNS 0900:2018 стандартад бүрэн нийцэж, ундны зориулалтаар хэрэглэхэд тохиромжтой, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

***Зөвлөмж:***

- Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 10 дугаар зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэгт заасны дагуу хог хаягдлаа ангилан ялгах, зориулалтын сав байрлуулах, хог хаягдлын цэгийг тохижуулах, хог хаягдлаа шатаахгүй байх шаардлагатай. Төсөл хэрэгжүүлэгч нь энгийн хог хаягдлыг орон нутгийн ТҮК-тэй хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээг жил бүр сунган ажиллах, аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн компанитай байгуулсан аюултай хог хаягдлыг ачиж, тээвэрлэх, устгуулах гэрээг жил бүр сунган ажиллах шаардлагатай.
- Төслийн автомашины зогсоол болон байнгын хөдөлгөөнтэй хэсэгт хатуу хучилттай зам талбай байгуулж, замын чиглэл болон зогсоолыг тодорхой тэмдэг тэмдэглэгээтэй болгох нь зүйтэй. Ингэснээр шороон замын тоосжилт, хөрс нягтралт, олон салаа зам үүсэх зэрэг сөрөг үзэгдлүүдээс сэргийлнэ.
- Олон салаа зам гаргах, зөвшөөрөлгүй газар зорчихоос сэргийлэх үүднээс зам, чиглэлийг заасан тэмдэг тэмдэглэгээг тодорхой байрлуулах шаардлагатай.
- Хүлцэх агууламжаас давсан хортой агууламжтай хөрсийг эзэлхүүн (м3)-ээр нь хуулан авч аюултай хог хаягдал устгах мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр Хог хаягдлын тухай хуулийн 5-р бүлэг. Аюултай хог хаягдлыг савлах, түр хадгалах, тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах шаардлага болон 34 дүгээр зүйл. Аюултай хог хаягдлыг ландфиллд булшилж устгахад тавигдах нэмэлт шаардлага тус тус холбогдох хуулийн дагуу орон нутгаас зөвшөөрөлтэй аюултай хог хаягдал хаядаг газар луу мэргэжлийн байгууллага зөөвөрлөж аюулгүй байдлыг хангах;
- Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 10 дугаар зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэгт заасны дагуу хог хаягдлаа ангилан ялгах, зориулалтын сав байрлуулах, хог хаягдлын цэгийг тохижуулах, хог хаягдлаа шатаахгүй байх шаардлагатай. Төсөл хэрэгжүүлэгч нь энгийн хог хаягдлыг орон нутгийн ТҮК-тэй хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээг жил бүр сунган ажиллах, аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн компанитай байгуулсан аюултай хог хаягдлыг ачиж, тээвэрлэх, устгуулах гэрээг жил бүр сунган ажиллах шаардлагатай.
- Төсөл хэрэгжүүлэгч талаас ногоон байгууламж бүхий мод сөөг ургуулж, арчлах шаардлагатай байна.
- Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн талбайд ногоон байгууламж хувь хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай учир нь модлог ургамал дуу чимээний бохирдлыг бууруулаад зогсохгүй орчны агаарыг цэвэршүүлэх ач холбогдолтой. Зайлшгүй

шаардлагатай биш бол машины дуут дохиог хэрэглэхгүй байхыг ажилчдад анхааруулах.

- Тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх, тоос дарагч бодис хэрэглэх, зам талбайн хучилтыг сайжруулах зэрэг инженерийн арга хэмжээ авах шаардлагатай. Харин үйлдвэрийн дотор орчны нийт тоосны хэмжээ MNS 4990:2015 стандартын хүлцэх түвшинд байгаа нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцэж байна. Гэсэн ч ажлын байрны агаарын чанарыг тогтмол хянаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Худгийн усны химийн найрлага, эрүүл ахуйн үзүүлэлтүүд нь MNS 1097:1970 болон MNS 900:2018 стандартын шаардлагад бүрэн нийцэж байгаа тул ундны зориулалтаар хэрэглэхэд тохиромжтой гэж үзнэ. Цаашид усны чанарыг хадгалах зорилгоор худгийн эргэн тойрны хамгаалалтын бүсийг хэвийн байлгах, бохирдол үүсгэх хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, усны чанарт улирал тутам хяналт-шинжилгээ хийхийг зөвлөж байна. Мөн усыг хүнсэнд хэрэглэхийн өмнө энгийн шүүлтүүрээр шүүн хэрэглэх нь илүү эрүүл ахуйн хувьд үр дүнтэй байж болно.

# АШИГЛАСАН НОМ, ХЭВЛЭЛ

1. Төв Азийн Усны Нөөцийн Нэгдсэн Менежментийн (УННМ) загвар бүс нутаг: Монгол (МоМо). Судалгааны ажлаас. УБ. 2016 он.
2. Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага стандарт MNS0900:2018
3. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага стандарт MNS4585: 2016
4. Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага стандарт MNS3298: 2019
5. Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт MNS5850: 2019
6. Д.Төмөрсүх, Ч.Жавзан. "Төв суурин газрын ус хангамж ба экологийн өөрчлөлт" сэдэвт суурь судалгааны тайлан. УБ.Геоэкологийн хүрээлэн. 2003он.
7. Д. Ааадорж, "Хөрс судлал". УБ. 2014 он
8. Д. Доржготов, "Монгол орны хөрс". УБ. 2003 он
9. http://sbemt.ub.gov.mn/?p=2420

# ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

| № | Хавсралтын нэр | Хуудасны тоо |
|---|---|---|
| 1 | Хөрсний агрохими, хүнд металлын шинжилгээний үр дүн | 1 |
| 2 | Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үр дүн | 1 |
| 3 | Агаарын бохирдол, дуу шуугианы хэмжилтийн үр дүн | 1 |
| 4 | Худгийн усны хүнд металл, ерөнхий химийн шинжилгээний үр дүн | 2 |

Хавсралт 1. Хөрсний агрохимийн шинжилгээний дүн

"НАРТ ШУУН КОНСАЛТИНГ" ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

MNAS

Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

**№ 25/05-31/1**

Захиалагч: **"Баянхангай консалтинг" ХХК**
Дээж авсан цэг: **"Алтан оршихуй групп" ХХК, Улаанбаатар, Багахангай дүүрэг**
Сорьц авсан огноо: **2025 оны 05 сар 22 өдөр**
Шинжилгээ хийсэн огноо: **05 сарын 31**

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| № | Дээж авсан гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, ds/m | Ялзмаг, % | $CaCO_3$, % | $NO_3$, мг/100г | Солилцох сууриуд, мг-экв/100 г | | Шим тэжээлийн элементүүд, мг/100г | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | $Ca^{+2}$ | $Mg^{+2}$ | $P_2O_5$ | $K_2O$ |
| Зүсэлт 1 | | | | | | | | | | | |
| 1 | 0-30 | 7.80 | 0.060 | 0.142 | 1.98 | 2.28 | 0.53 | 14 | 12 | 4.3 | 10 |
| Зүсэлт 2 | | | | | | | | | | | |
| 2 | 0-20 | 7.88 | 0.065 | 0.154 | 1.84 | 1.14 | 0.58 | 13 | 10 | 3.9 | 14 |
| Зүсэлт 3 | | | | | | | | | | | |
| 3 | 0-20 | 7.97 | 0.056 | 0.133 | 2.08 | 0.96 | 0.49 | 14 | 9 | 4.2 | 14 |

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

| № | Дээж авсан гүн, см | Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| Зүсэлт 1 | | | | | | | | |
| 1 | 0-30 | 3.1 | 57.2 | 20.1 | 8.7 | 5.0 | 5.9 | 19.6 |
| Зүсэлт 2 | | | | | | | | |
| 2 | 0-20 | 3.7 | 58.0 | 18.2 | 10.6 | 4.1 | 5.4 | 20.1 |
| Зүсэлт 3 | | | | | | | | |
| 3 | 0-20 | 4.9 | 58.0 | 17.2 | 9.4 | 3.2 | 7.3 | 19.9 |

3. ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН. 1ГР ХӨРСӨНД

| № | Дээжний дугаар | Нянгийн тоо | Гэдэсний савханцрын титр (*E.coli*) MNS 3297:2019 | | *Анаэробын (Cl.perfringens* MNS 3297:2019 | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Шинжилгээний хариу | Шинжилгээний хариу | Бохирдлын зэрэг | Шинжилгээний хариу | Бохирдлын зэрэг |
| 1 | Зүсэлт 1 | $7.1*10^5$ | ≥0.1 | 1 | ≥0.1 | 1 |

** Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарна*

2025 ОНЫ 05 САРЫН 31 1

Хавсралт 2. Хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүн

4. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Дээж авсан газар, Газар зүйн байршил | Дээж авсан гүн, см | Cr | Pb | Cd | Zn | Cu | Ni |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг | мг/кг |
| Зүсэлт 1 | 0-30 | 52.2 | 19.3 | 0.0 | 9.5 | 10.0 | 3.4 |
| Зүсэлт 2 | 0-20 | 61.3 | 24.3 | 0.0 | 40.4 | 12.0 | 13.0 |
| Зүсэлт 3 | 0-20 | 46.2 | 21.8 | 0.0 | 5.7 | 10.3 | 9.5 |
| Зөвшөөрөгдөх дээд хэмжээ,MNS 5850:2019 | | | | | | | |
| Элсэрхэг хөрс | | 60 | 50 | 1 | 100 | 60 | 60 |
| Шавранцар хөрс | | 100 | 70 | 1.5 | 150 | 80 | 100 |
| Шаварлаг хөрс | | 150 | 100 | 3 | 300 | 100 | 150 |

*Харгалзах түвшин * Жич: Энэхүү шинжилгээний харуу нь тухайн цэгийн дээжинд хамаарна*

*ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд* MNS3310:1991, MNS ISO10390, *Хөрсний механик бүрэлдэхүүн»* MNS6824:2020, *Эрүүл Ахуйн Шинжилгээний Стандарт* MNS 5367:2004, MNS6341:2012,*Хүнд металлуудыг хаат дарсанд атомн шингээлтийн спектрометрээр* MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: Х.УУГАНЦЭЦЭГ, С.НЯМДАШ

ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор

Нарт ШУУН Консалтинг ХХК

2025 ОНЫ 05 САРЫН 31 2

Хавсралт 3. Агаарын бохирдол болон дуу шуугианы хэмжилтийн үр дүн

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**
**БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН**
**ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

**СОРИЛТЫН ДҮН**

| | |
|---|---|
| Дугаар он/№ | : 2025/А-385-386 |
| Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | "Алтан Оршихуй Групп" ХХК |
| Сорьц авсан хүний нэр, албан тушаал | : Д.Сувд агаарын хэсэг |
| Сорьцын тоо, төрөл | : 2 агаар, 2 дуу чимээ |
| Сорьц авсан огноо | : 2025.05.22 |
| Сорьцын тодорхойлолт | : Улаанбаатар хот Багахангай дүүрэг 1-р хороо Төгрөг Баян Хангай ХХК Ахуй мандал дахин боловсруулах үйлдвэр |
| Шинжилгээний аргын стандарт | : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021 MNS 6768:2019, СА3 А07-2016 |
| Шинжилсэн огноо | : 2025.06.02 |
| Хуудасны тоо | : 1/1 |

Үр дүн :

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий | Азотын давхар исэл | Нийт тоос /TSP/ | Дуу чимээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мг/м$^3$ | | | ДБА |
| 1 | Гадна талбай | 25/05/22 | 11:30 | 0.012 | 0.048 | 0.530 | 48 |
| **Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)** | | | | **0.450** | **0.200** | **0.500** | **60** |
| 2 | Үйлдвэр дотор орчин | 25/05/22 | 12:00 | 0.014 | 0.028 | 0.560 | 66 |
| **Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл мэнд.Ажлын байрны орчин.Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015** | | | | **2** | **2** | **2** | **-** |
| **Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл мэнд.Шуугианы норм.Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 6768:2019** | | | | | | | **85** |

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч : Э.Оюунтуяа

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч: Д.Түмэндэлгэр

Хавсралт 4. Худгийн усны ерөнхий, эрүүл ахуй болон хүнд металлын хэмжилтийн үр дүн

“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

№ 25/06-03/-1

Захиалагч: **“Баянхангай консалтинг” ХХК**
Дээж авсан цэг: **“Алтан оршихуй групп” ХХК, Багахангай**
Сорьц авсан огноо: **2025 оны 05 сар 22 өдөр**
Уст цэгийн төрөл: **гүний худаг**
Харилцах утас:
Аргын стандарт: **MNS1097:1970**

| Катион | 1 дм³ | | | Анион | 1 дм³ | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мг/л | мг-экв/л | мг-экв/% | | мг/л | мг-экв/л | мг-экв/% |
| $Ca^{++}$ | 66.00 | 3.29 | 74.80 | $CO_3^{--}$ | 0.00 | 0.00 | 0.00 |
| $Mg^{++}$ | 10.00 | 0.82 | 18.69 | $HCO_3^-$ | 156.00 | 2.56 | 58.07 |
| Fe | 0.00 | 0.00 | 0.00 | $Cl^-$ | 36.00 | 1.02 | 23.07 |
| $K^+$ | 1.00 | 0.03 | 0.58 | $SO_4^{--}$ | 36.00 | 0.75 | 17.04 |
| $Na^+$ | 6.00 | 0.26 | 5.93 | $NO_3^-$ | 5.00 | 0.08 | 1.83 |
| **Дүн** | **83.00** | **4.40** | **100.00** | **Дүн** | **233.00** | **4.40** | **100.00** |

Анион катионуудын нийлбэр:
($\sum$А+К **316 мг/л**
$HCO_3$-ийн хагасыг хассан анион, катионуудын нийлбэр: **238 мг/л**
***Физик үзүүлэлтүүд***
Өнгө: 0-**өнгөгүй**
Үнэр: 0-**үнэргүй**
Булингар: **Булингаргүй**

Тунгалаг: **Тунгалаг**
Хуурай үлдэгдэл, мг/л: **162 ppm**
Ерөнхий **хатуулаг: 4.11 мг-экв/л**
*/ бага хатуулагтай ус /*
Урвалын орчин: pH- **6.96**
Цахилгаан дамжуулах чадвар:
EC **-0.472 ds/m**
TDS: **199 ppm**

$$M(0.32) = \frac{HCO3\ 58\ [Cl\ 23\ SO4\ 17]}{Ca\ 75\ [Mg\ 19\ Na\ 6]}$$

***Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, II төрлийн цэнгэг буюу дунд зэрэг эрдэжилттэй, бага хатуулагтай ус.***

1. УСНЫ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН. 1 МЛ УСАНД

| № | Ус | Нянгийн тоо | Гэдэсний савханцрын титр (*E.coli*) | *Анаэробын (Cl.perfringens)* |
|---|---|---|---|---|
| | | Шинжилгээний хариу | Шинжилгээний хариу | Шинжилгээний хариу |
| 1 | худаг | 7 | Илрээгүй | Илрээгүй |

Хавсралт 4. Худгийн усны ерөнхий, эрүүл ахуй болон хүнд металлын хэмжилтийн үр дүн

2. УСНЫ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Ус | Дээж авсан гүн, см | Усны хүнд металлын агууламж, мг/л | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Cr | Pb | Cd | Zn | Cu | Ni |
| Гүний худаг | - | 0.0 | 0.0 | 0.0 | 0.033 | 0.014 | 0.0 |
| **Зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 4586:1998** | | | | | | | |
| **Хүлцэх агууламж** | | **0.01** | **0.01** | **0.00** | **0.01** | **0.01** | **0.01** |

*Жич: усны сорьцыг шинжлүүлсэн байгууллага хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно*

*ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Эрүүл Ахуйн Шинжилгээний Стандарт MNS 5668:2006, Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ* MNS 0900:2018 MNS ISO 8288:1999, *Атом шингээлтийн спектрометрээр,)*

ЗАДЛАН ШИНЖЛЭГЧ: С.НЯМДАШ MSc

ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: Г.СОЛОНГО Ph.D, Дэд проф.

Нарт ШУҮН Консалтинг ХХК